

Төслийн нэр: Монгол улсад нийгмийн эгэх хариуцлагын бэхжүүлэх төсөл (МУНЭХБ)

**НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР ОРОН НУТАГТ ТҮНШЛЭН АЖИЛЛАХ СОНИРХОЛ,  
ТУРШЛАГАТАЙ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ТЭДГЭЭРИЙН ЭВСЭЛ/СҮЛЖЭЭ БАЙГУУЛЛАГЫН  
МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ЖАГСААЛТ**

	Байгууллага	Холбоо барих төлөөлөл	Цахим хаяг	Утасны дугаар
1	Хил хязгааргүй алхам ТББ	Н. Баярсайхан	И-мейл: swb_bayar@yahoo.com; swb.ngo@gmail.com	7000-6061, 99724869
2	“Захиргааны Шинэ Санаачлага” ТББ	С. Цэрэнпүрэв	<a href="mailto:info@pani.org.mn">info@pani.org.mn</a>	99284057, 70129788, 99907119
3	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг ТББ	Б. Батжаргал, А. Бүрэнжаргал	Э-шуудан: info@mea.org.mn, burnee@mea.org.mn	Утас: 976-11-310663, 318149, Факс: 976-11-324285
4	“Байгаль орчин эрүүл мэнд төв” ТББ	Л.Дугармаа	Майл: dula_lod@yahoo.com	Утас: 95257562
5	“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл	Д.Тунгалаг	coordinator@all4education.mn	утас: 99129020
6	Транспэрэнси Интернэшнл-Монгол	О. Батбаяр Э. Мөнхжаргал	<a href="mailto:batbayar@transparency.mn">batbayar@transparency.mn</a> ; <a href="mailto:o_batbayar@yahoo.com">o_batbayar@yahoo.com</a> munkhjargal@transparency.mn	9999943, 99091215
7	“Худалдан авах ажиллагааны түншлэл” ТББ	Н. Отгонжаргал, Г. Батхуяг	email: norotgon@gmail.com, b99282812@gmail.com,	770228128, 976-99082509, 976-99282812
8	Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо	Б. Чулуундолгор	chuluundolgor@gmail.com	89982929 75952929
9	MONFEMNET үндэсний сүлжээ	Энхжаргал, Д. Должинсүрэн	<a href="mailto:coordinator@monfemnet.org">coordinator@monfemnet.org</a> <a href="mailto:officer@monfemnet.org">officer@monfemnet.org</a>	91002121 99158175
10	Монголын Багш-Эцэг эхийн холбоо ТББ (МБЭЭХ)	Л.Ариунзул, холбооны менежер	<a href="mailto:pta.mongolia@gmail.com">pta.mongolia@gmail.com</a>	96004010
11	Хөгжлийн хэлхээ	А. Долгор	Hogjiinhelhee_center@yahoo.com	91193364.9
12	Сэтгэлзүйн мэдрэмж, НҮТББ/	Ч. Сэмжидмаа(PhD)	semjidmaa_choijil@yahoo.com	99118560, 77050819,
13	Үнэнхатамж ТББ	Ж.Сайнзаяа	sainzayajd@yahoo.com	99193498
14	Монголын тува эмэгтэйчүүдийн “Тува ээж” ТББ	А.Ариунаа	<a href="mailto:and_ariunaa@yahoo.com">and_ariunaa@yahoo.com</a>	99427052, 93057530

15	<b>Хүний Эрх Хөгжил төв</b>	У. Мандхайцэцэн	<a href="mailto:tsetsentur@yahoo.co.uk">tsetsentur@yahoo.co.uk</a> ; <a href="mailto:chrd@mongolnet.mn">chrd@mongolnet.mn</a>	<a href="tel:11325721">11 325721 / +976 11 319037; 99194455</a>
16	<b>АРДЧИЛЛЫН БОЛОВСРОЛ ТӨВ (ДЕМО)</b>	Г. Ундрал	И-мэйл: undral.gombodorj@gmail.com	Утас: 99164419
17	<b>Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг (МНЭММН)</b>	Б. Энхтуяа	Э-шуудан: mphpa.mongolia@gmail.com	Утас/Факс: 976-11-325190
18	<b>Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ</b>	П.Цэвээн	tzeveen@yahoo.com	99010297
19	<b>“Ил тод байдал сан” ТББ</b>	Д.Цэрэнжав, Б.Бямбасүрэн	tseren2005@yahoo.com, budvaabyambaa@yahoo.com	99163657, 88100882
20	<b>Хүний хөгжил, Нөхөн үржихүйн эрүүл мэнд/Эрх ТББ-уудын сүлжээ</b>	Б.Алтанчимэг-Ерөнхий зохицуулагч	<a href="mailto:ag232616@yahoo.com">ag232616@yahoo.com</a>	976-93090506/976-88784388

	МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	ТАНИЛЦУУЛГА ТАЙЛБАР
1	ТББ-ын нэр /Монгол, Англи хэл дээр/ Холбогдох барих мэдээлэл /хаяг, цахим шуудан, утас, вэб хуудас, нэмэлт мэдээллийн холбоос, холбоо барих гол ажилтны мэдээлэл/	<p><b>Хил хязгааргүй алхам ТББ</b> Steps Withuot Borders NGO</p> <p>Чингэлтэй дүүрэг. 4-р хороо. НҮБ 8/2 байр. 202 тоот Ажлын утас: 7000-6061 Шуудангийн хайрцаг: Улаанбаатар 46А. ш/х-416 И-мейл: <a href="mailto:swb_bayar@yahoo.com">swb_bayar@yahoo.com</a>; <a href="mailto:swb.ngo@gmail.com">swb.ngo@gmail.com</a> Цахим хуудас: <a href="http://www.swbm.wordpress.com">www.swbm.wordpress.com</a> Холбоо барих: Тэргүүн Н.Баярсайхан. Утас: 99724869/ 88724869</p>
3	Байгууллагын үүсгэн байгуулагдсан товч түүх	<p>Хил хязгааргүй алхам ТББ нь 2000 оны эхээр уул уурхайн лиценз хувь хүнд, тооны хязгааргүй олгогдож, түүнд төрийн байгууллага хяналт тавьж чадахгүй, нөөц чадавх нь хүрэлцэхгүйгээс орон нутагт уул уурхайн компани болон уугуул иргэд хоорондын зөрчил ид хүчтэй өрнөж байх үед байгуулагдсан.</p> <p>Энэ үед уул уурхайн салбарын эрхзүйн орчин одоог бодвол их сул, салбарын бодлого уялдаагүйн дээр хэрэгжилт хангалтгүй байсан. Үүнээс болж компаниуд АМХЭГ-аас зөвшөөрөл авсан л бол эргэж төлөвлөгөө, тайлагнал байхгүй, ил тод нээлттэй байдал бүр сураггүй, энэ талаар иргэд ИНБ-үүд ч шаардах, хяналт тавих чадавх бүрдээгүй байсан үе.</p> <p>Энэ үед зөвхөн компанитай тэмцэлдээд хуулийн хэрэгжилт шаардаад ямар ч үр дүнгүй, цаг их алддаг, компаниас гадна төр бас буруутай оролцогчийн нэг байна гэдгийг Онги голынхон хөдөлгөөнд байхдаа сайтар мэдэж авсан. Ийм учраас дан ганц байгаль орчны зөрчлөөс гадна төр болон компани хүний эрхийг хамгаалах, тэдэнд ИНБ эрхэд суурилсан хяналт тавих, шаардах замаар байгаль орчны хамгаалах, шударга ёсыг тогтоох нь зүйтэй юм гэж үзсэн.</p> <p>Мөн 2003- оноос уул уурхайтай нутаг бүрт иргэний хөдөлгөөнүүд байгуулагдаж бидэнд хандаж зөвлөгөө туслалцаа ихээр авч эхэлсэн. Ингээд Өмнөговь, Дундговь, Өвөрхангай аймаг тус бүрээс нэг нэг хүн, нийслэлийн 3, нийт 8 хүн ярилцаад нийслэлээс үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, зөвлөн тусалдаг, өргөн суурьтай үйлчилгээ үзүүлдэг болох шаардлага хэрэгцээнээс үүдэж Хил хязгааргүй алхам ТББ-ыг үүсэн байгуулсан. Үүнээс хойш дүрэмдээ 2 удаа өөрчлөлт оруулж, жил бүрийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа нээлттэй гаргаж ирсэн. Энэ жил 20/20 стратеги боловсруулж байна.</p>
4	Байгууллагын тухай товч хураангуй	<p>Хил хязгааргүй алхам төрийн бус байгууллага нь байгалийн нөөцийн ашиглалт, менежементээс үүдэлтэй хүний эрхийн зөрчлийг судлах, хамгаалах, олон нийтийн засаглалын үйл явцад оролцох оролцооны эрхийг хангах, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, мониторинг,</p>

		нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус, нийгэмд үйлчилдэг байгууллага. <sup>1</sup>
5	<b>Эрхэм зорилго</b>	Хөдөөгийн тогтвортой хөгжлийг дэмжиж, нийгэмд шударга ёс хэвшүүлэхэд алслагдсан орон нутгийн иргэд, ИНБ-ын бодит оролцоог нэмэгдүүлж улс орондоо ардчилсан иргэний нийгмийг цогцлоон хөгжүүлэхэд оршино <sup>2</sup>
6	<b>Гол зорилтот бүлэг</b>	Хил хязгааргүй алхам ТББ нь эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд үндсэн хоёр хөтөлбөртэй ажилладаг. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>○ “Эрхэд суурилсан- Тогтвортой хөгжил” хөтөлбөр нь Орон нутгийн хүмүүсийн иргэний болон улс төрийн, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийг сайжруулах, хамгаалах, үүний дотор эрх мэдэл багатай бүлгийн эрхэд анхаарч, тэдэнд эрх, эрх чөлөөгөө эдлэх, илэрхийлэхэд нь шаардагдах мэдлэг, чадавх олгох, дэмжлэг үзүүлэх улмаар засаглалд иргэдийн оролцооны болон хөгжих эрх баталгаажихад нөлөөлөх зорилготой хөтөлбөр.</li> <li>○ “Байгальд ээлтэй- Тогтвортой хөгжил” хөтөлбөр нь байгалийн нөөцийг ашиглах хууль тогтоомж, төрийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөг үнэлэхэд орон нутгийн иргэдийн үр дүнтэй оролцох, тасралтгүй хяналтаа тогтооход шаардагдах мэдлэг, чадавхийг тогтмол олгож, засаглалын ил тод нээлттэй, хариуцлагатай байдлыг шаардахад нь хүлээн зөвшөөрөгдөх үр дүнтэй оролцооны арга хэрэгсэл, механизмүүдыг бий болгож хэрэглэх замаар байгалийн нөөцийг удирдахад хүний эрхэд сурилсан хандлагыг нэвтрүүлэх зорилготой хөтөлбөр хэрэгжүүлдэг.</li> <li>○ Үндсэн хөтөлбөрүүдийн хүрээнд аль болох эрх нь зөрчигдөх, зөрчигдсөн эрхээ шаардаж нэхэж чадахгүй байх эрсдэлтэй, эрх мэдэл багатай хэсэгт хүрч тэднийг мэдлэг, мэдээллээр хангах, улмаар эрх агуулагчийнх нь хувьд эрхмэдэлжүүлэхийг зорьж байна. Мөн хөгжлийн оролцогч бусад талуудын тэдэнд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх талаар нөлөөллийн ажлууд хэрэгжүүлэхийг зорьж байна. Орон нутгийн түвшинд байгуулагдсан ТББ-уудыг чадавхижуулах ажлыг орхихгүй хийхийг хичээдэг. Энэ нь орон нутгийн түвшинд иргэд эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг эдлүүлэх, боломжийг тэлж өгөхөд ач холбогдолтой гэж үздэг.</li> </ul>
7	<b>Хүний нөөц</b>	<u>Байгууллагын дээд удирдлага:</u> Удирдах зөвлөлийн гишүүд: 5 1).Ж.Баатархүү эр; 2).Н.Баярсайхан эм; 3).С.Амарсанаа эр; 4).Л.Номин эм; 5).Д.Дэгдцэрэн эм; <u>Гол гишүүд, мэргэжилтнүүд:</u> <u>Ажлын алба 3:</u> 1. А.Сүхбаатар эр; 2).Ч.Энхмандах эм; 3).Ч.Мандахбаатар эр 2. МУИС болон ХУИС-ын сайн дурын ажилтан, оюутануудтай хамтран ажилладаг. 3. 2010 оноос хойш үндсэн 3 ажилтантай ажиллаж, ажилчдын НДШ болон ХАОАТ зэрэг татваруудыг хуулийн дагуу төлж тайлагнаж ирсэн болно.

<sup>1</sup> - Хил хязгааргүй алхам ТББ-ын 2014-2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаас дэлгэрүүлж авч үзнэ үү

<sup>2</sup> - Хил хязгааргүй алхам ТББ-ын 2014 оны 1-р улирлын УЗ-ийн гишүүдийн хурлаар баталсан шинэчилсэн дүрэм.

8	<b>Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулсан орон нутаг /аймаг, дүүрэг/, орон нутгийн салбарын сүлжээ</b>	<p>Үндсэн хөтөлбөр 1 хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Увс аймаг, Тэс, Давст</li> <li>• Говь-Алтай аймаг, Бигэр, Дэлгэрэх</li> <li>• Дундговь аймаг, Эрдэнэдалай,</li> <li>• Өвөрхангай аймаг, Уянга сум</li> <li>• Баян Өлгий аймаг, Ногоон нуур зэрэг 10 аймаг, нийслэлийн Налайх дүүрэг</li> </ul> <p>Үндсэн хөтөлбөр 2 хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дундговь аймгийн Хулд, Луус, Дэлгэрхангай, Өлзийт, Гурвансайхан</li> <li>• Өмнөговь аймаг, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс</li> <li>• Булган аймаг, Бүрэгхангай</li> <li>• Дорноговь аймгийн Хатанбулаг, Айраг, Иххэт</li> <li>• Баянхонгор, Хэнтий, Дорнод, Өвөрхангай зэрэг мөн 8 аймагт</li> </ul>
9	<b>Өнгөрсөн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл</b>	<p><i>Үндсэн хөтөлбөр 1 хүрээнд:</i></p> <ol style="list-style-type: none"> <li>1. <u>Хүний эрхийн чиглэлээр:</u> МУ дахь хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг хангахад соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хийж, хүний эрхийн төлөв байдлын тайлан боловсруулж НҮБ хороод ХЭ-ийн зөвлөлд хүргэх, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад ЗГ –ын байгууллагуудтай хамтран ажиллах,</li> <li>2. <u>Иргэдийн засаглалын үйл ажиллагаанд оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:</u> Хөгжлийн бодлого шийдвэрийг боловсруулж батлах хэрэгжүүлж үнэлэх бүхий л үе шатанд хүний эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэх, арга зүй гарын авлага материал боловсруулж түгээх, талуудыг чадавхжуулах замаар иргэдийн төрийн үйл ажиллагаа, засаглалд оролцоог нэмэгдүүлэх</li> <li>3. <u>Талуудыг соён гэгээрүүлэх чиглэлээр:</u> Тогтвортой хөгжлийн үзэл санаа ойлголтыг таниулан сурталчлах, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангахыг талуудад таниулах, гарын авлага материал боловсруулж түгээх</li> </ol> <p><i>Үндсэн хөтөлбөр 2 хүрээнд:</i></p> <ol style="list-style-type: none"> <li>4. <u>Уул уурхайн салбарын засаглалыг сайжруулах чиглэлээр:</u> салбарын харилцаанд оролцогч үүрэг хүлээгч талуудын үйл ажиллагаанд ил тод нээлттэй байдлыг бий болгох, төрийн байгууллага, компани талуудын олон нийтийн өмнө эргэн нээлттэй тайлагналыг бий болгох, арга зүй боловсруулж хэрэглээг бий болгох</li> <li>5. <u>Хөгжлийн оролцогч талуудын хамтын ажиллагааны чиглэлээр:</u> хөгжлийн асуудлаар талууд хамтран ажиллах, зөвшилцөх, харилцан үүрэг хүлээж, хариуцан хэрэгжүүлж эргэн тайлагнах тогтолцоог бий болгох, хамтран орон нутгийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх чадавх олгох</li> </ol>
10	<b>Нийгмийн эгэх хариуцлага, Ил тод байдал, Сайн засаглалыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 5 хүртэлх тооны санаачилга, төсөл</b>	<p><b>Төслийн нэр, хэрэгжүүлсэн хугацаа, хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Уул уурхайн салбарт компани болон төрийн байгууллага хамтраад иргэддээ нээлттэй тайлагнах “ОУИТБС-г хэрэгжүүлэх олон талт нээлттэй хэлэлцүүлэг” -ийг говийн 3 аймгийн 7 суманд тогтмол зохион байгуулж иргэд, ИНБ нь асуулга тавих замаар үнэн бодитой мэдээллийг авах, нээлттэй хариуцлага шаардах боломж бий болж, нээлттэй тайлагнах ажил тогтмолжиж байна.</li> <li>2. Уул уурхай бүхий сумдын иргэд нь компаний болон захиргааны байгууллагын салбарын үйл ажиллагаа, хяналтад мөрдөх хууль</li> </ol>

		<p>тогтоомжийн хэрэгжилтийг 2 талаас асууж үнэлдэг “Иргэдийн үнэлгээний карт”-ын аргыг боловсруулж иргэдэд зааж сургаснаар Дорноговь аймгийн Хатанбулаг, Даланжаргалан сумдад тогтмол ажиллагаа болсон. Ингэснээр иргэд бодит мэдээллээр хангагдаж бодитой дүгнэлт хийх, талууд ил тод нээлттэй мэдээлэл өгөх, эргэн тайлагнах, хамтран зөвшилцөж зөрчилтэй асуудлыг шийддэг болж байна.</p> <p>3. Говийн бүсийн 2 аймгийн 6 суманд ажиллаж тухайн сумын нутаг дэвсгэр дэх байгалийн нөөцөд түшиглэсэн эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй талуудын оролцоотой олон талт зөвлөл байгуулж, “Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө”<sup>3</sup> боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Ингэснээр тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд зөвхөн төрийн байгууллага, компаинуудаас гадна иргэд, малчид, аялал жуулчлалын салбар хөгжлийн оролцогч талууд бөгөөд эдгээрт тодорхой үүрэг хариуцлагыг сайн дураар хүлээх замаар орон нутгаа хөгжүүлэх эерэг хандлага оролцоо бий болж байна.</p> <p>4. Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Хэл шинжлэлийн салбар сургуулийн захиргаа, оюутануудтай хамтран тухайн сургууль дах оюутны суралцах орчин, сургуулиас үзүүлж байгаа үйлчилгээний чанарт “ Иргэдийн онооны карт”-аар үнэлгээ хийж үйлчилгээний чанар, сургалтын орчныг сайжруулсан байна.</p> <p>5. Төрийн байгууллагын албан тоотын хариу хугацаандаа, аль болох өмнө өгөх, өргөдөл гомдлыг шүүрхай шийдвэрлэхэд гардаг хүнд суртал, олон шат дамжлага чиргэдлийг багасгах зорилгоор УУЯ, БОАЖНХЯ, АМГ зэрэг байгууллагуудтай кейсээр нөлөөлж ажилласанаар ТББ-уудад хандах хандлага, шүүрхай байдалд ахиц гарч байна. Мөн цахим хуудас дахь мэдээллийн чанар, шинэчлэгдэхгүй байдалд тогтмол үндэслэлтэйгээр анхааруулж ажилласнаар нөхцөл байдал дээрдэж байгааг ИНБ-ынхан үнэлж байна.</p> <p><b>Хамтарч ажилласан байгууллага, хандивлагч байгууллага:</b>  <u>1 дүгээр ажил:</u> Нээлттэй нийгэм форум, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн санхүүжүүлж, ТАН эвсэл, орон нутгийн захиргаа, уугуул иргэд хамтран ажилласан  <u>2 дугаар ажил:</u> 2012 онд Дэлхийн банк, БОШ-2 төслийн санхүүжилтийн хүрээнд хийгдэсэн ажил, Түүнээс хойш байгууллага өөрийн нөөц бололцоогоор Иргэдийн үнэлгээний карт АМТХ тогтворгүй байдагтай холбоотой тогтмол шинэчлэх шаардлагаар шинэчлэгдээд явдаг. Орон нутгийн иргэд ч өөрсдийн нөөц бололцоог ашиглан ИҮК-ын үнэлгээг хийж байна. Хамтрагчид: орон нутгийн захиргаа, уугуул иргэд, ИНБ ууд, компаниуд  <u>3 дугаар ажил:</u> Азийн сангийн санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хамтрагчид: орон нутгийн захиргаа, ИТХ болон иргэд, ТББ-ууд, компаниуд хамтран ажиллаж байна.  <u>4 дүгээр ажил:</u> Канад сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Ардчиллын боловсрол төвтэй хамтран хэрэгжүүлсэн</p>
--	--	---

<sup>3</sup>- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь зөвхөн тодорхой бизнесийн төсөл дээр хийгдэх хуультай. Харин сумдад БО чиглэлийн 10 гаруй тус тусдаа хөтөлбөр хэрэгждэг. Сумын хэмжээнд БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх, эргэн үнэлж, тайлагнахад хөгжлийн оролцогч талуудын оролцоог хангасан, БО ны бүрэлдэхүүн хэсэг бүрийг нэгтгэсэн цогц төлөвлөгөө болж буйгаараа манай улсад анхдагч болж байгаа болно.

		<p><i>5 дугаар ажил:</i> Хил хязгааргүй алхам ТББ өөрийн нөөц бололцоонд түшиглэн хэрэгжүүлж байна.</p> <p><b>Гол үйл ажиллагаа, хүрсэн үр дүн тус бүрийн талаар товч нэг өгүүлбэр:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Хөгжил нь төв хөдөөд ялгаатай байх ёсгүй гэж үздэг. Иргэд олон нийт, иргэний нийгмийн бүлгүүд, бүх шатны төр, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд, хувийн хэвшлийнхэн бүгд орон нутгийн хөгжлийн оролцогч талууд гэж үздэг. Ийм учраас ажилласан аймаг сумдадаа хөгжлийн олон талт оролцогчдын бүтэцтэй зөвлөлүүдийг байгуулж, тогтвортой чадавхижуулж ажилладаг. Эдгээр зөвлөл нь Нээлттэй хэлэлцүүлэг, нээлттэй тайлагнал, Иргэдийн үнэлгээний болон онооны картаар үнэлгээ хийх замаар эргэх хариуцлагыг сайжруулах, засаглалын нээлттэй, ил тод байдлыг бий болгох арга хэрэгслүүдийг туршиж үр дүнтэй нь батлагдсан тул бусад аймаг, сумдад түгээх ажил хийгдэж байна.</li> <li>Аймаг, сумын хөгжлийн олон талт зөвлөл нь орон нутгийнхаа “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлж байгаа нь бусад аймаг, сумдад загвар болох ажил болж байна.</li> </ul>
11	Тус байгууллага МАСАМ төслийн үйл ажиллагаанд ямар давуу талууд үзүүлэн орон нутгийн оролцогч талуудад хэрхэн чадварлаг зөвлөгч/түншлэгч байж чадах талаар тайлбарлана уу.	<ul style="list-style-type: none"> <li>Манай байгууллага хуримтлуулсан мэдлэг туршлага, боловсруулж гаргасан арга зүй, хэрэглэгдэхүүн бүхнээ бусдад хуваалцах замаар орон нутгийн хөгжлийг дэмжиж хамтран ажиллах хүсэлтэй байдаг.</li> <li>Говийн бүсийн экологи, хөгжлийн асуудлыг нэгдсэн байдлаар харж, иргэд ИНБ-ын оролцоо хүчийг нэгтгэх замаар нөлөөлөх, чадавх бэхжүүлэх зорилгоор Өмнөговь, Дорноговь, Дундговь аймагт сүүлийн 10 шахам жил ажиллаж ирлээ.</li> <li>Иймд бүсийн хэмжээнд экологи, хөгжлийн бодлогод нөлөөлж ажиллах зорилгоор энэ хавраас Говьсүмбэр аймгийн Дэлхийн зөн ОУБ-тай үндсэн хөтөлбөр 1-ийн хүрээнд иргэдтэй ажиллаж эхлээд байна.</li> </ul>
12	Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож/төлөвлөж буй аймаг/дүүрэг /хэрэв байгаа бол/	<ul style="list-style-type: none"> <li>“Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г говийн бүсийн дөрвөн аймгийн хэмжээнд бүх сумдад хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байгаа болно.</li> <li>Иймд МАСАМ төслийн хүрээнд Говь сүмбэр аймагт ажиллах бүрэн боломжтой ч бусад аймгуудад ажиллах хамтын ажиллагааны суурь, туршлага мэдээлэл байгаа болно.</li> </ul>
13	Тус байгууллагын талаарх дээр дурьдагдаагүй нэмэлт мэдээлэл /3 хүртэлх өгүүлбэр/	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутагт ажиллахдаа орон нутгаас нь сурч буй оюутнуудыг сурч буй чиглэлийн дагуу үйл ажиллагаанд татан оролцуулах замаар нутаг сэтгэл, нутагтаа ажиллах хандлагыг нэмэгдүүлэх, орон нутгийн захиргааатай холбож нөлөөлж ажилладаг.</li> <li>Нутгийн зөвлөлтэй нь хамтрах замаар нутгийнх нь хөгжлийн үйл ажиллагаанд оролцоог хангаж ажилладаг туршлагатай.</li> </ul>
14	МУНЭХБ төслийн хүрээнд тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад	<ul style="list-style-type: none"> <li>Байгууллагын мэдээллийг бусадтай хуваалцахад татгалзах зүйлгүй бөгөөд хавсралтаар 2014-2015 оны байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсаргалаа.</li> <li>Тун удахгүй байгууллага цахим хуудсаа шинэчлэх тул илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой болно.</li> </ul>

<p>илгээн, цаашид холбоо барихыг зөвшөөрч буй эсэх талаар мэдэгдэнэ үү.</p>	
---	--



	МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	МЭДЭЭЛЭЛ
1	ТББ-ын нэр /Монгол, Англи хэл дээр/	“Захиргааны Шинэ Санаачлага” ТББ “Public Administration New Initiatives” NGO
2	Холбогдох барих мэдээлэл /хаяг, цахим шуудан, утас, вэб хуудас, нэмэлт мэдээллийн холбоос, холбоо барих гол ажилтны мэдээлэл, хэрэв орон нутгийн салбартай бол хаяг/	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Амарын гудамж, Соёлын төв өргөө, Б корпус, 426 тоот Цахим шуудан: <a href="mailto:info@pani.org.mn">info@pani.org.mn</a> Вэб хуудас: <a href="http://www.pani.org.mn">www.pani.org.mn</a> Фейсбүүк хуудас: “Захиргааны Шинэ Санаачлага” ТББ Холбоо барих ажилтны мэдээлэл: “Захиргааны Шинэ Санаачлага” ТББ-ын гүйцэтгэх захирал Сундуйн Цэрэнпүрэв, утасны дугаар 99284057. 70129788 . 99907119
3	Байгууллагын үүсгэн байгуулагдсан товч түүх	Захиргааны Шинэ Санаачлага ТББ 2008 онд байгуулагдсан.Монголд төрийн болон төрийн бус байгууллагын захиргааны шинэтгэлийг дэмжих эрчимжүүлэх чиглэлээр байгуулагдсан.
4	Байгууллагын тухай товч хураангуй	Манай байгууллага нь : <ul style="list-style-type: none"> <li>• “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ байгууллага</li> <li>• Төлсөн Авснаа Нийтэл эвслийн гишүүн</li> <li>• “Ил Тод Байдлыг Дэмжих Түншлэл”-ийн гишүүн байгууллага</li> <li>• “ Хөгжлийн Ажиглагч” Иргэний Нийгмийн Нээлтэй Форумын гишүүн байгууллага</li> </ul>
5	Эрхэм зорилго	Төрийн захиргааны шинэтгэлийг эрчимжүүлэхэд олон нийтийн санаачлагыг өрнүүлэх замаар төрийн төв ба орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудтай хамтран ажиллаж, төрийн байгууллагын нээлттэй, ил тод, хэрэглэгч төвтэй үйлчилгээг сайжруулахад нөлөөлнө.
6	Гол зорилтот бүлэг	Төрийн байгууллага, Иргэд, Түншлэл,84-р сургуулийн 11 –р ангийн сурагчид
7	Хүний нөөц	<b>Байгууллагын дээд удирдлага:</b> <ol style="list-style-type: none"> <li>1. Ч. Сосормаа- “Захиргааны Шинэ Санаачлага” ТББ-ын үүсгэн байгуулагч, АНУ-ын Колорадогийн их сургуулийг Төрийн захиргааны магистраар сурч төгссөн.</li> </ol> <b>ГҮЙЦЭТГЭХ АЛБА:</b> <ol style="list-style-type: none"> <li>1. Сундуйн Цэрэнпүрэв- “Захиргааны Шинэ Санаачлага” ТББ-ын гүйцэтгэх захирал, эдийн засгийн ухааны магистр</li> <li>2. Т.Намжил- “Захиргааны Шинэ Санаачлага” ТББ-ын зөвлөх, Шинжлэх ухааны доктор</li> <li>3. Б.Мөнгөнтуул- “Захиргааны Шинэ Санаачлага” ТББ-ын судалгааны ажилтан, докторант</li> <li>4. Ж.Сонинбаяр- МУИС, ХУДС-ийн багш, “Захиргааны Шинэ Санаачлага” ТББ-ын зөвлөх, эрх зүйч бакалавр, математик, багшийн магистр цолтой.</li> </ol>

		5. М.Солонго- “Захиргааны Шинэ Санаачлага” ТББ-ын төслийн зохицуулагч, санхүүгийн ажилтан, олон улсын бизнес менежмент бакалавр зэрэгтэй.
8	<b>Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулсан орон нутаг /аймаг, дүүрэг/, орон нутгийн салбарын сүлжээ</b>	Нийслэлийн 9 дүүрэг, Баян-Өлгий, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай, Ховд, Завхан, Хөвсгөл, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий, Архангай болон Увс аймгуудад төслийн хүрээнд хүрч ажиллаж байсан.
9	<b>Өнгөрсөн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл</b>	Төрийн байгууллагын ил тод, хариуцлагатай байдал, Сайн засаглалыг дэмжих , Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйлчилгээг эрчимжүүлэх зэрэг тэргүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна.
10	<b>Нийгмийн эгэх хариуцлага, Ил тод байдал, Сайн засаглалыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 5 хүртэлх тооны санаачилга, төсөл</b>	<p><b>Төслийн нэр, хэрэгжүүлсэн хугацаа, хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</b></p> <p><b>Сайн засаглалыг дэмжих чиглэлээр:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Орон нутгийн төсвийн ил тод байдалд иргэдийн оролцоог хангах тухай” журмын хэрэгжилтийн үнэлгээ төсөл /Шилэн түрийвч аян/ 2013.04 сараас-2013.09-р сар хүртэл үргэлжилсэн- Багануур дүүргийн 38-р цэцэрлэг</li> <li>2. Орон нутгийн Хөгжлийн сангийн үйл явцад холбогдох эрх зүйн орчинг сайжруулах хүрээнд Хан-уул дүүрэгт кейс судалгаанд зөвлөх үйлчилгээ- 2015.11.15- 2015.12.15- ны хооронд- Хан-уул дүүрэг 6-р хороо</li> </ol> <p><b>Нийгмийн эгэх хариуцлагын чиглэлээр:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>3. “Төсвийн ил тод байдалд мониторингийн төсөл”- Орон нутгийн хөгжлийн сангийн ил тод байдалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хяналтын зөвлөл байгуулсан 2014.09- 2014.12 сар хүртэл- Баянгол дүүрэг7- хороо, Багануур дүүрэг 1-р хороо, Баянзүрх дүүрэг 16-р хороо</li> </ol> <p><b>Ил тод байдлын чиглэлээр:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>4. “Мэдээллийн ил тод байдал ба Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээн дэхь төсвийн багцын ил тод нээлттэй байдалд мониторинг хийх” төсөл- 2015.04- 2015.06 сар хүртэл- Эрүүл мэнд Спортын яам, Боловсрол Соёл Шинжлэх ухааны яам</li> <li>5. “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтэнд мониторинг хийх” төсөл 2015.07-2016.01 сар хүртэл- Нийслэлийн 6 дүүргийн 30 хэлтэс</li> </ol>
		<p><b>Хамтарч ажилласан байгууллага, хандивлагч байгууллага:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Нээлттэй Нийгэм форумын санхүүжилтээр</li> <li>2. Олон улсын хөгжлийн агентлаг, АНУ-ын Азийн сангийн санхүүжилтээр, дэмжлэгээр</li> </ol>
		<p><b>Гол үйл ажиллагаа, хүрсэн үр дүн тус бүрийн талаар товч нэг өгүүлбэр</b></p> <p>1.“Орон нутгийн төсвийн ил тод байдалд иргэдийн оролцоог хангах тухай” журмын хэрэгжилтийн үнэлгээ төсөл</p>

Үйл ажиллагаа- Зорилтот бүлэг болох Багануур дүүргийг Иргэдийн хяналт оролцоотой загвар дүүрэг болгон хөгжүүлж бусад аймаг, дүүргүүдэд түгээн дэлгэрүүлэх

Үр дүн- Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зориулсан /сургууль, цэцэрлэгийн төсөвийн хөтөч/ гарын авлагыг хийсэн.

**2.**Орон нутгийн Хөгжлийн сангийн үйл явцад холбогдох эрх зүйн орчинг сайжруулах хүрээнд Хан-уул дүүрэгт кейс судалгаанд зөвлөх үйлчилгээ

Үйл ажиллагаа- Орон нутгийн Хөгжлийн сангийн үйл явцад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Хан-Уул дүүргийн иргэдийн оролцооны түвшинг тодорхойлон, хууль эрх зүйн түвшинд сайжруулах асуудлуудыг тодорхойлж санал, зөвлөмж боловсруулах.

Үр дүн- ОНХС-ийн санал авах хуудсыг шинэчлэн төсөл хэлбэрээр боловсруулсан.

**3.**Төсвийн ил тод байдалд мониторингийн төсөл

Үр дүн- Баянгол, Баянзүрх, Багануур дүүргийн 7,19,1-р хороонд Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэнд хяналт тавих иргэдийг зохион байгуулж, хяналтын зөвлөл байгуулсан.Хяналтын зөвлөлийн дүрэмтэй болсон, Хороон даргатай ажиллах санамж бичиг боловсруулсан

Үйл ажиллагаа- Иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж ОНХС-ийн талаар мэдээлэл өгөх, сайн дурын үндсэн дээр Иргэний хяналтын зөвлөл байгуулан, иргэдэд сургалт зохион байгуулж

**4.**“Мэдээллийн ил тод байдал ба Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээн дэхь төсвийн багцын ил тод нээлттэй байдалд мониторинг хийх” төсөл

Үр дүн- Санхүү төсвийн мэдээлэлийг инфографикаар байршуулах аргачлалаар Сургуулийн болон цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны норм ил тод болгон цахим хуудасыг хөгжүүлсэн. БСШУЯ-ын цахим хуудсыг дээрх хуулийн дагуу “ИЛ ТОД БАЙДАЛ” цэс нээн Төсвийн ил тод байдал хэсэгт иргэд илүү мэдэхийг хүсдэг мэдээллүүдийг сонгон авч зурган хэлбэрээр иргэдэд ойлгомжтой байдлаар байршуулж өгсөн.

Үйл ажиллагаа- “Мэдээллийн ил тод байдал ба Мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу Зорилтот 2 яамны төрийн албан хаагчид сургалт зохион байгуулж ,мэдээллийг олон нийтэд ил тод болгох арга аргачлалд сургасан

**5.**“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн хэрэгжилтэнд мониторинг хийх” төсөл

Үр дүн- Дээрх хэлтсүүдийн цахим хуудас болон мэдээллийн самбаруудад мэдээллээ байршуулж байгаа үйл явц дахь давуу тал болон дутагдлууд тодорхой болсон бөгөөд иргэдээс авсан судалгаа болон мониторинг хийх явцад гарсан дүгнэлтүүд дээр үндэслэн санал зөвлөмж боловсруулсан.

Үйл ажиллагаа- Нийсэлийн 6 дүүргийн 30 хэлтэсийн цахим хуудсанд хуулийн 7 зүйлийн заатын хүрээнд мэдээлэл ил тод, хүрээмжтэй,байнгын, цаг хугацаандаа мэдээлэлж байгаа байдалд шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд мониторинг хийсэн.

1 1	<b>Тус байгууллага нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд ямар давуу талууд үзүүлэн орон нутгийн оролцогч талуудад хэрхэн чадварлаг зөвлөгч/түншлэгч байж чадах талаар тайлбарлана уу. (жишээлбэл: арга хэрэгсэл, механизм ашигласан туршлага, зорилтот бүлэгт гарсан үр нөлөө, 5 хүртэлх өгүүлбэрт бичих)</b>	<p>1. Эрх зүйн орчныг иргэдэд таниулах, соён гэгээрүүлэхэд тэднийг татан оролцуулахад :</p> <ul style="list-style-type: none"> <li>• Орон нутгийн асуудлаар хэлэлцүүлэг хийх</li> <li>• Туршлага судлах</li> <li>• Гарын авлага, танилцуулга хийх</li> <li>• Нийгмийн /олон нийтийн/ аудит</li> <li>• Олон нийтийн санал асуулга</li> <li>• Олон нийтэд зориулсан мэдээлэл</li> <li>• Жүжигчилсэн хэлбэрээр хуулийг сурталчлах зэрэг арга хэрэгслүүдийг ашигладаг.</li> </ul> <p>/Мэдээллийн ил тод байдал ба Мэдээлэл авах эрхийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сан. Төсвийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиудтай холбоотой бичиг баримтууд/</p>
1 2	<b>Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож/төлөвлөж буй аймаг/дүүрэг /хэрэв байгаа бол/</b>	<p><u>Үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож буй дүүрэг:</u> Сонгинохайрхан дүүрэг</p> <p><u>Үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож буй аймаг:</u> Хөвсгөл аймаг Говьсүмбэр аймаг</p>
1 3	<b>Тус байгууллагын талаарх дээр дурьдагдаагүй нэмэлт мэдээлэл /3 хүртэлх өгүүлбэр/</b>	<p>1. Канад сангийн санхүүжилтээр “Өсвөр насны хүүхдийг эрт болон албадан гэрлэлтээс урьдчилан сэргийлэх нь” төслийн хүрээнд нийслэлийн 84-р сургуулийн сурагчидтай хамтран жүжигчилсэн тоглолт хийж, СД-н дээр буулган 300 ширхэгийг нийслэлийн сургуулиудад тарааж олны хүртээл болгосон.</p> <p>Мөн Баян-Өлгий аймгийн төвийн 6 сургууль, 2 сумуудад очиж хэлэлцүүлэг хийн ахлах ангийн сурагчдад жүжгээ толилуулсан.</p> <p>2. Ил Тод Байдлыг Дэмжих Түншлэлийн хүрээнд Зөрчлийн тухай хууль, Хяналтын тухай хуулийн төсөлд сайн дураар үнэлгээ хийсэн.</p>
1 4	<b>Төслөөс тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, холбоо барихыг зөвшөөрөх эсэх.</b>	<p>МУНЭХБ төслийн хүрээнд манай байгууллагын дээрх мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, холбоо барих, хамтран ажиллахыг зөвшөөрч байгаагаа дуулгахад таатай байна.</p>

№	МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	МЭДЭЭЛЭЛ
1	<b>ТББ-ын нэр /Монгол, Англи хэл дээр/</b> <b>Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг</b> ТББ Mongolian Education Alliance NGO	
2	<b>Холбогдох барих мэдээлэл /хаяг, цахим шуудан, утас, вэб хуудас, нэмэлт мэдээллийн холбоос, холбоо барих гол ажилтны мэдээлэл, хэрэв орон нутгийн салбартай бол хаяг/</b> <b>Манай хаяг:</b> Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө 15/1, Улаанбаатар-28, Монгол Улс-14251 Утас: 976-11-310663, 318149, Факс: 976-11-324285 Вэбсайт: <a href="http://www.mea.org.mn">www.mea.org.mn</a> , <a href="http://www.mongoleducation.mn">www.mongoleducation.mn</a> Э-шуудан: <a href="mailto:info@mea.org.mn">info@mea.org.mn</a>	
3	<b>Байгууллагын үүсгэн байгуулагдсан товч түүх</b> Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (БХАН) нь боловсролын салбарын шинэчлэлийг дэмжих, боловсролын салбарт ажиллагсад, хүүхэд залуучуудыг ардчилсан нийгмийн идэвхтэй иргэн байх мэдлэг чадварыг эзэмшүүлэхээр ажиллаж буй нийгэмд үйлчилдэг, төрийн бус байгууллага бөгөөд 2004 оны 8 дугаар сард байгуулагдсан. Бид 1996 оноос эхлэн боловсролын шинэчлэл, иргэний нийгмийн хөгжлийг дэмжих агуулга, арга зүйг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөр, төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн (Соросын Сан)-ийн Боловсролын хөтөлбөрүүдийн залгамж холбоо болж үүсгэн байгуулагдсан билээ.	
4	<b>Байгууллагын тухай товч хураангуй</b> БХАН нь “ТББ-ын ёс зүйн зарчим”-д нэгдэн, мөрдлөгө болгон ажилладаг бөгөөд бидний явуулж буй бүхий л үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд нь шашин, улс төр, эдийн засгийн ашиг сонирхлоос ангид, ашгийн бүс хэлбэрээр нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэхэд чиглэгддэг. Бид жил бүр үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа олон нийтэд нээлттэй тайлагнадаг ба санхүүгийн үйл ажиллагаандаа хөндлөнгийн аудит хийлгэдэг болно.  <b>БХАН-ИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:</b> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр</b> нь хүүхэд төвт сургалтын орчин арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлж өөрийн туршлага, нөөц, агуулга, арга зүйгээрээ сургуулийн өмнөх болон бага боловсролын түвшинд танил болсон ба бага насны хүүхдийг хөгжүүлэх чанартай арга зүйн зарчмыг тэдний хамааралт талуудад эзэмшүүлэхэд анхаарч ажилладагийн зэрэгцээ бага насны хүүхдийн хөгжилд эцэг эх, гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.</li> <li>- <b>Сургууль, багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр</b> нь сургуульд суурилсан шинэчлэл, сургалтын арга зүйг хөгжүүлэхэд томоохон хувь нэмрээ оруулдаг ба багш нарыг ажлын байранд нь хөгжүүлж, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагаагаараа үндэсний хэмжээнд танигдсан.</li> <li>- <b>Хүүхэд, залуучуудын хөгжлийн хөтөлбөр</b> нь хүүхэд, залуучуудын үзэл бодлоо илэрхийлэх болон оролцооны эрхийг дэмжих олон хөтөлбөрийг санаачлан тогтвортой хэрэгжүүлж, тэднийг ардчилсан нийгмийн идэвхтэй гишүүн байх, дэлхийн улс үндэстний соёл, зан заншил, уламжлалыг хүндэтгэх, бие даан суралцах чадвартай бие хүн болон төлөвшихөд дэмжлэг үзүүлдэг.</li> <li>- <b>Боловсролд тэгш хамруулах хөтөлбөр</b> нь хүүхэд бүрийн ялгаатай байдал, хувийн онцлогийг хүндэтгэсэн боловсролын үйлчилгээг хүртэх, боловсролын байгууллага бүр өөрийн бодлого, үйл ажиллагаа, соёлдоо боловсролд тэгш хамруулах үзэл санааг төлөвшүүлэхэд анхаардаг.</li> </ul>	

	<ul style="list-style-type: none"> <li>- <b>Судалгаа, үнэлгээ:</b> Боловсролын салбарт тулгамдаж байгаа асуудлуудыг илрүүлэх, шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох судалгааны ажлуудаас гадна хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үнэлгээний ажлыг тогтмол гүйцэтгэдэг мэргэшсэн багтай.</li> <li>- <b>Хэвлэн нийтлэл:</b> БХАН нь багш, суралцагч, эцэг эх, боловсролын салбарт ажиллагсдад зориулсан ном, гарын авлага, сургалтын материалуудыг тогтмол боловсруулан, хэвлэж олон нийтийн хүртээл болгохын зэрэгцээ “Нээлттэй сургууль” сар тутмын сониноороо дамжуулан боловсролын байгууллагын ажилтан, иргэд, олон нийтийн хөгжлийг дэмжсэн олон төрлийн мэдээллийг тогтмол түгээдэг.</li> </ul>		
<b>5</b>	<p><b>Эрхэм зорилго</b></p> <p>Монголын боловсролд нээлттэй нийгмийн үнэт зүйл болох ил тод байдал, хариуцлагатай хандах чадвар, боловсрол эзэмших тэгш эрх, оролцоог нэмэгдүүлэхэд байгууллага, хувь хүмүүсийн үр нөлөөтэй хамтын ажиллагааг хөгжүүлж боловсролын чанарыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулахад оршино.</p>		
<b>6</b>	<p><b>Гол зорилтот бүлэг</b></p> <p>БХАН нь хүн бүр насан түршдаа суралцагч байж, чанартай, тэгш хамруулсан, хүртээмжтэй боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэхийн тулд бүхий л нөөц, боломж, анхаарлаа төвлөрүүлэн ажилладаг.</p> <p><b>Зорилтот бүлэг:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- 0-10 насны хүүхэд, тэдний эцэг эх, багш</li> <li>- ЕБС-ийн удирдах ажилтан, багш, ажилтан, эцэг эх, суралцагч болон хамааралт талууд</li> <li>- 18-35 насны залуучууд</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд</li> <li>- Боловсролын үйлчилгээнд хамрагдах боломж бага нийгмийн эмзэг бүлгийн иргэд</li> <li>- Боловсролын бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид</li> </ul>		
<b>7</b>	<table border="1"> <tr> <td><b>Хүний нөөц</b></td> <td> <p><b>Байгууллагын дээд удирдлага:</b> Удирдах зөвлөл</p> <p><b>Гол гишүүд, мэргэжилтнүүд:</b></p> <p>Гүйцэтгэх захирал: Б.Батжаргал (99035671)</p> <p>Олон нийтийн харилцааны менежер: А.Бүрэнжаргал (99038843)</p> <p>Сургууль, багшийн хөгжил хөтөлбөрийн менежер: Н.Нарантуяа (99875949)</p> <p>Хүүхэд, залуучуудын хөтөлбөрийн менежер: Г.Оюунжаргал (94080810)</p> <p>Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн менежер: Д.Ариунчимэг (99092245)</p> <p>Боловсролд тэгш хамруулах хөтөлбөрийн менежер: О.Саранцэцэг (99030887)</p> <p>Үндсэн ажилтны тоо: 10      Үндэсний сургагч багшийн тоо: 40</p> </td> </tr> </table>	<b>Хүний нөөц</b>	<p><b>Байгууллагын дээд удирдлага:</b> Удирдах зөвлөл</p> <p><b>Гол гишүүд, мэргэжилтнүүд:</b></p> <p>Гүйцэтгэх захирал: Б.Батжаргал (99035671)</p> <p>Олон нийтийн харилцааны менежер: А.Бүрэнжаргал (99038843)</p> <p>Сургууль, багшийн хөгжил хөтөлбөрийн менежер: Н.Нарантуяа (99875949)</p> <p>Хүүхэд, залуучуудын хөтөлбөрийн менежер: Г.Оюунжаргал (94080810)</p> <p>Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн менежер: Д.Ариунчимэг (99092245)</p> <p>Боловсролд тэгш хамруулах хөтөлбөрийн менежер: О.Саранцэцэг (99030887)</p> <p>Үндсэн ажилтны тоо: 10      Үндэсний сургагч багшийн тоо: 40</p>
<b>Хүний нөөц</b>	<p><b>Байгууллагын дээд удирдлага:</b> Удирдах зөвлөл</p> <p><b>Гол гишүүд, мэргэжилтнүүд:</b></p> <p>Гүйцэтгэх захирал: Б.Батжаргал (99035671)</p> <p>Олон нийтийн харилцааны менежер: А.Бүрэнжаргал (99038843)</p> <p>Сургууль, багшийн хөгжил хөтөлбөрийн менежер: Н.Нарантуяа (99875949)</p> <p>Хүүхэд, залуучуудын хөтөлбөрийн менежер: Г.Оюунжаргал (94080810)</p> <p>Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн менежер: Д.Ариунчимэг (99092245)</p> <p>Боловсролд тэгш хамруулах хөтөлбөрийн менежер: О.Саранцэцэг (99030887)</p> <p>Үндсэн ажилтны тоо: 10      Үндэсний сургагч багшийн тоо: 40</p>		
<b>8</b>	<p><b>Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулсан орон нутаг /аймаг, дүүрэг/, орон нутгийн салбарын сүлжээ</b></p> <p>Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн Боловсролын газар, хэлтэс, аймаг, нийслэлийн болон 396 сум, багийн 680 ЕБС, 210 цэцэрлэг, Багш бэлтгэх сургуулиуд</p>		
<b>9</b>	<p><b>Өнгөрсөн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл</b></p> <p><b>БХАН-ийн өнгөрсөн таван жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Боловсролын байгууллагын ажилтнуудыг ажлын байрнаасаа хөндийрөхгүй тасралтгүй хөгжих, тэдэнд боловсролын чанарыг дээшлүүлэхэд баримтлах зарчмуудыг эзэмшүүлэхэд зөвлөн туслах, ном гарын авлагаар тасралтгүй хангах;</li> <li>- Сургууль, цэцэрлэг, боловсролын байгууллага нь орон нутгийнхаа иргэд, олон нийтийн хөгжил, гэгээрлийн төв болох “Олон нийтийн оролцоот нээлттэй сургууль”-ийн стандартыг туршин хэрэгжүүлж, үр дүнг хуваалцах;</li> <li>- Боловсролд тэгш хамрагдах нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусын асуудал бус амьдарч буй орчин, нийгэм эдийн засаг, соёл, ёс заншил зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байгаа нийт хүүхэд, залуусын асуудал гэдэг ойлголтыг олон нийт, хамааралтай талуудад өгөх, боловсролд тэгш хамруулах загвар сургууль, цэцэрлэгтэй болох;</li> </ul>		

	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд, залуучуудыг хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, орон нутгийнхаа хөгжил, өөрчлөлтийн талаарх мэдээллийг нээлттэй болгож, сайн засаглалыг бэхжүүлэхэд дуу хоолойгоо нэгтгэх, үзэл бодлоо илэрхийлэх, оролцоотой байхад чиглүүлэх;</li> <li>- Эцэг эх, олон нийтийг хүүхдийнхээ боловсролд анхаарч, тэднийг ойлгох, хөгжүүлэхэд гол дэмжлэг үзүүлэгч байх арга зүйг эзэмшүүлэх, СӨБ-д хамрагдаж чадаагүй хүүхдүүдийг эцэг эх, бага ангийн багшийн хамт сургуульд бэлтгэх, эцэг эхчүүдэд ашиглах боломжтой, 3 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн илрүүлэлтийн хэрэгслийг орчуулан, тохируулж ашиглах замаар хүүхдийн хөгжил дэх эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх гэх мэт.</li> </ul>
10	<p><b>Нийгмийн эгэх хариуцлага, Ил тод байдал, Сайн засаглалыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 5 хүртэлх тооны санаачилга, төсөл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Төслийн нэр, хэрэгжүүлсэн хугацаа, хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</b></li> <li>- <b>Хамтарч ажилласан байгууллага, хандивлагч байгууллага:</b></li> <li>- <b>Гол үйл ажиллагаа, хүрсэн үр дүн тус бүрийн талаар товч нэг өгүүлбэр:</b></li> </ul>
	<p><b>“Номын гэр” хөтөлбөр (Тогтмол үйл ажиллагаа)</b>  <i>Хамарсан аймаг/сум/дүүрэг/хороо:</i> Нийслэлийн Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн хороод, Төв аймгийн Жаргалнт сум  <i>Хамтрагч байгууллагууд:</i> Хаан банк сан, Ротари клуб, Канадын сан, Бээжин дэх Нидерландын ЭСЯ, Дэлхийн Зөн ОУБ, АНУ-ын иргэд  <i>Гол үйл ажиллагаа:</i> Иргэд, хүүхэд, залуучуудыг өөрийн амьдарч буй газартаа ойр номын сангийн болон бусад мэдээлэл үйлчилгээ авах олон нийтийн хөгжлийн төв байгуулдаг.</p>
	<p><b>“Санхүүгийн хямралын үед нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд боловсролын үйлчилгээг хүргэх нь” техникийн тусалцааны төсөл (2010-2012)</b>  <i>Хамтрагч байгууллагууд:</i> БСШУЯ, Азийн Хөгжлийн Банк  <i>Гол үйл ажиллагаа:</i> Эдийн засгийн хямралтай холбоотой боловсролын салбарт тулгамдсан асуудлыг судалж түүнийг даван туулах боломжит хувилбарыг санал болгох. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны төлбөрийг төрөөс бүрэн даах болсон нь нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт, өрхийн эдийн засагт хэрхэн нөлөөлсөн талаарх судалгаа</li> <li>- ЕБС-ийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативт суурилсан зардлын томъёонд оруулах өөрчлөлтийн санал</li> <li>- Сурагчийн дүрэмт хувцасны үнийг бууруулах арга замууд</li> <li>- Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, эцэг эх, бусад талуудын оролцоог хангах зэрэг болно.</li> </ul>
	<p><b>Алслагдсан болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох нь” төсөл (2009-2013)</b>  <i>Хамтрагч байгууллага:</i> БСШУЯ, Азийн Хөгжлийн Банк  <i>Гол үйл ажиллагаа:</i> Алслагдсан хөдөө (Баян-Өлгий, Өмнөговь, Булган, Хэнтий) болон шилжин суурьшигчид хамгийн ихтэй дүүрэг (Сонгинохайрхан, Баянзүрх)-т гэр цэцэрлэг байгуулан хувилбарт сургалтын хэлбэрийг турших, тухайн гэр цэцэрлэгээр дамжуулан эцэг эх, олон нийтийг сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаанд татан оролцуулахад чиглэсэн болно.</p>
	<p><b>Боловсролын чанарыг сайжруулахад чиглэгдсэн чанарын судалгааны ажлууд</b>  <i>Хамтрагч талууд:</i> НҮБ-ын Хүүхдийн Сан, Нээлттэй Нийгэм Сан, Боловсролын Иргэний Нийгмийн Сан/Бүх Нийт Боловсролын Төлөө Иргэний Нийгмийн Эвсэл  <i>Гол үйл ажиллагаа:</i> Боловсролын чанарыг сайжруулахад чиглэгдсэн судалгааны ажлуудыг тогтмол хийж тухайн асуудалд олон нийт, бодлого боловсруулагчид, бусад хамааралтай талуудын анхаарлыг хандуулах, сайжруулах санал, зөвлөмжүүдийг боловсруулан, хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлага зохион байгуулах замаар нөлөөллийн ажлууд хийдэг. Сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгааны ажлуудад:</p>

	<ul style="list-style-type: none"> <li>- Монголын багш нар: Багшлахуйн хангамж, мэргэжлийн хөгжил, тогтвортой ажиллах боломж эмпирик судалгаа, 2011</li> <li>- Боловсролын салбарын санхүүжилтийн тойм судалгаа (1995-2012 он), 2014</li> <li>- Боловсролын чанарт нөлөөлөх багш нарын хөдөлмөрлөх ба үйлдвэрчний эвлэлийн эрхүүд, 2014</li> <li>- Төрийн бус өмчийн сургуульд төрөөс үзүүлж буй санхүүгийн дэмжлэг, түүний үр нөлөө, 2015</li> </ul>
	<p><b>“Бага насны хүүхдийн хөгжлийн эрт илрүүлэлт” хөтөлбөр</b>  <i>Хамтрагч талууд:</i> Нээлттэй Нийгэм Форум, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хамтарсан төв комисс  <i>Гол үйл ажиллагаа:</i> 3 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн үзүүлэлтийн дагуу эцэг эхчүүд, СӨБ-ын байгууллагын багш, эмч, өрхийн болон сумын эрүүл мэндийн төвийн мэргэжилтнүүд ашиглах боломжтой асуулгаар хүүхдийн хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийн магадлалыг илрүүлэх анхан шатны илрүүлэлтийн хуудсуудыг Монголын хөхцөлд тохируулан хувирган ашиглах, ингэснээр эцэг эхчүүдийн бага насны хүүхдийн хөгжлийн талаарх ойлголт хандлага, оролцоо нэмэгдэн, орон нутгийн түвшинд хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг илрүүлэн шаардлагатай арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх</p>
	<p><b>“Хариуцлагатай залуу манлайлагч” хөтөлбөр (2013-2017)</b>  <i>Хамтран ажилласан талууд:</i> ЮНЕСКО-ийн Бээжин дэх салбар, аймгуудын Нийгмийн хөгжлийн хэлтэс  <i>Гол үйл ажиллагаа:</i> 20-35 насны залуучуудын хүний эрх, манлайллын үр чадвар нэмэгдүүлэн тэднийг амьдарч буй аймаг, орон нутгийнхаа хөгжлийн төлөө сайн дураараа эвлэлдэн нэгдэж, дуу хоолойгоо илэрхийлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгддэг.</p>
11	<p><b>Тус байгууллага нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд ямар давуу талууд үзүүлэн орон нутгийн оролцогч талуудад хэрхэн чадварлаг зөвлөгч/түншлэгч байж чадах талаар тайлбарлана уу. (жишээлбэл: арга хэрэгсэл, механизм ашигласан туршлага, зорилтот бүлэгт гарсан үр нөлөө, 5 хүртэлх өгүүлбэрт бичих)</b></p> <p>Манай байгууллага аливаа үйл ажиллагаа, үйлчилгээгээрээ хамааралт талуудаа идэвхжүүлэх, тэднийг байнгын мэдээлэл, оролцоотой байхад ихээхэн анхаардаг билээ. Ингэснээр тэдний нийгмийн хөгжил дэх оролцоо нэмэгдэн, өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх, орон нутгийнхаа хөгжилд хувь нэмрээ оруулах соёлд суралцдаг. Мөн бидний хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд <b>сургалт+зөвлөн туслах+шинэ санаачилгыг дэмжин хэрэгжүүлэх</b> гэсэн цогц байдлаар хэрэгждэг учир хүн өөрөө шинэ зүйлд суралцаад түүнийгээ өөрийн санаачилгаар баяжуулан туршин хэрэгжүүлж бусаддаа эерэгээр нөлөөлдөг болно.</p>
12	<p><b>Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож/төлөвлөж буй аймаг/дүүрэг /хэрэв байгаа бол/</b></p> <p>Бид өнгөрсөн 12 жилийн хугацаанд үндэсний хэмжээнд хүрч үйлчилж, боловсролын салбарын бүх байгууллагатай хамтран ажилласнаараа бахархдаг. Энэ ажлын далайц нь бидэнд илүүг хийж бүтээх урам зориг, шинэ санаачилгыг үргэлж өгдөг юм. Цаашид манай байгууллага хүн бүрийг насан туршдаа суралцагч байхад илүү анхаарч төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахаар төлөвлөж байна.</p>
13	<p><b>Тус байгууллагын талаарх дээр дурьдагдаагүй нэмэлт мэдээлэл /3 хүртэлх өгүүлбэр/</b></p> <p>БХАН нь БСШУЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээр албан ёсоор баталгаажсан төрөлжсөн сургалтуудыг боловсролын байгууллагын ажилтнууд, иргэд олон нийтийн хөгжлийг дэмжин тогтмол зохион байгуулдаг ба үндэсний хэмжээнд зохион байгуулагдах эрх бүхий сургалтын 50 орчим хувийг манай байгууллагын сургалтууд эзэлдэг.</p> <p><b>Манай байгууллага:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Боловсролын Бодлогын Төвүүдийн Сүлжээ (<a href="http://www.edupolicy.net">http://www.edupolicy.net</a>)</li> <li>- Олон Улсын Алхам Алхмаар Холбоо (<a href="http://www.issa.nl/">http://www.issa.nl/</a>)</li> <li>- Ази, Номхон Далайн Суурь болон Насанд Хүрэгчдийн Боловсролын Нийгэмлэг (<a href="http://www.aspbae.org">www.aspbae.org</a>)</li> <li>- Олон Улсын Мэтгэлцээний Боловсролын Холбоо (<a href="http://www.idebate.org">www.idebate.org</a>) зэрэг дэлхий олон орны байгууллагуудыг эгнээндээ нэгтгэсэн сүлжээнүүдийн гишүүн бөгөөд тэдэнд өөрийн орны онцлог нөхцөл байдлыг ойлгуулж дэмжлэг авах, агуулга арга зүйгээс нь суралцах, ажилтнуудаа чадваржуулан байнга харилцаа холбоотой хамтран ажилладаг болно.</li> </ul>



14	<b>МУНЭХБ төслийн хүрээнд тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, цаашид холбоо барихыг зөвшөөрч буй эсэх талаар мэдэгдэнэ үү.</b>
	<p>Бидний үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн бүхий л мэдээлэл нээлттэй, ил тод байдаг учир та бүхнийг энэхүү мэдээллийг бусдад түгээн дэлгэрүүлж, манай байгууллага болон холбогдох ажилтнуудтай холбоо барихыг хүлээн зөвшөөрч байна.</p> <p>Манай байгууллага өөрсдийн туршлага, нөөц, давуу талдаа үндэслэн боловсролын чиглэлийн аливаа төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх боломжтойгоо илэрхийлж байна.</p>

	МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	МЭДЭЭЛЭЛ
1	ТББ-ын нэр /Монгол, Англи хэл дээр/	<b>“Байгаль орчин эрүүл мэнд төв”</b> ТББ “Nature Environment & Health Center” ИГО
2	Холбогдох барих мэдээлэл /хаяг, цахим шуудан, утас, вэб хуудас, нэмэлт мэдээллийн холбоос, холбоо барих гол ажилтны мэдээлэл, хэрэв орон нутгийн салбартай бол хаяг/	Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жүүлчны гудамж, Центр 34. № 504 Майл: <a href="mailto:dula_lod@yahoo.com">dula_lod@yahoo.com</a> Утас: 95257562 Холбоо барих: Л.Дугармаа гүйцэтгэх захирал
3	Байгууллагын үүсгэн байгуулагдсан товч түүх	Эрүүл ахуй, Халдвар Нян Судлалын Улсын Институт, Байгаль Орчны Яам /хуучин нэрээр/ Дэлхийн Байгаль Хамгаалах Сан, Эрүүл мэндийн салбаруудад мэргэжилээрээ 10-30 жил ажилласан хүмүүс санаачлан тус ТББ-ыг байгуулсан түүхтэй
4	Байгууллагын тухай товч хураангуй	“Байгаль орчин эрүүл мэнд төв” ТББ нь Хүний эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх хүрээнд байгаль орчныг бохирдох, доройтохоос сэргийлэх, нийгмийн эрүүл ахуй, эрүүл мэндийн талаар мониторинг судалгаа хийх, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж, гүйцэтгэж байна.
5	Эрхэм зорилго	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалахын төлөө, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах.
6	Гол зорилтот бүлэг	Иргэд
7	Хүний нөөц	Байгууллагын дээд удирдлага: Удирдах зөвлөлийн дарга Л.Долгормаа. PhD. Зөвлөх Д.Содном. Профессор. Гол гишүүд, мэргэжилтнүүд: Ж.Чимгээ Экологич инженер; Д. Зулбаяр Мэдээллийн технологч; Р.Должинсүрэн Токсикологч их эмч; Ч.Оюунгэрэл Хими технолог инженер; Н.Алтанцэцэг Хүнсний технологч, нийгмийн ажилтан Л.Дугармаа Эрүүл ахуйч эмч; Б, Анусэцэн Хуульч.
8	Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулсан орон нутаг /аймаг, дүүрэг/, орон нутгийн салбарын сүлжээ	Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Налайх дүүрэг, Дархан, Эрдэнэт, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймаг, зарим сумууд
9	Өнгөрсөн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл	<ul style="list-style-type: none"> <li>• Орчины бохирдолоос байгаль орчин болон хүний эрүүл мэндийг хамгаалах</li> <li>• Хог хаягдлын менежмент бодлого</li> <li>• Мониторинг, судалгаанууд</li> <li>• Сургалт, зөвлөгөө</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Нөлөөллийн ажлууд</li> <li>• Ном товхимол, сургалтын аргачлал боловсруулах</li> </ul>
10	<p>Нийгмийн эгэх хариуцлага, Ил тод байдал, Сайн засаглалыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 5 хүртэлх тооны санаачилга, төсөл</p>	<p><u>Төслийн нэр:</u> “Эмнэлэг, шүдний эмнэлэг, эмийн сангуудад мөнгөн үс агуулсан багаж хэрэгслэл хэрэглэж, борлуулж байгаа эсэхэд мониторинг судалгаа” 8 сар, Улаанбаатар хотын 3 дүүрэг, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг зарим сумууд, Санхүүжүүлэгч: ННФ Үр дүн: Зөвлөмж боловсруулан, судалгааны дүнг</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ ЭМСЯам болон холбогдох байгууллагад танилцуулсан</li> <li>▪ Эмийн сангууд, болон эмнэлэгүүдэд мөнгөн устай багаж хэрэгслэл хэрэглэх явдал эрс буурсан.</li> </ul> <p><u>Төслийн нэр:</u> “Орон нутгийн байгаль орчны асуудал эрхэлсэн мэргэжилтнүүдийг чадавхижуулах” 3 хоногийн сургалт. /Төвийн болон Хангайн бүсийн аймаг, сумууд/ Санхүүжүүлэгч: БОНХЯам Үр дүн: Аймаг, сумдын байгаль орчин, эрүүл ахуйн мэргэжилтнүүдэд сургалт явуулж, гэрчилгээ олгосон</p> <p><u>Төслийн нэр:</u> “Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх компани т ажил” 9 сар. Санхүүжүүлэгч:ННФ Үр дүн: Аюултай, халдвартай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх асуудлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүйгээр зайлуулах мөн хоргүйжүүлэх, халдваргүйжүүлэх аргуудыг тусгасан 3 ном бичиж хэвлүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>○ Аюултай хаягдал</li> <li>○ Цахим ба цахилгаан хэрэгслэлийн хаягдал</li> <li>○ Асбестын хаягдал</li> </ul> <p>Зарим аймаг, хот сумдын байгаль хамгаалах болон эрүүлийг хамгаалах газар эрүүл ахуйч нарт ном болон файлаар хүргүүлсэн.</p> <p><u>Төслийн нэр:</u> “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” 0115-MON(SF) төсөлийн ил тод, нээлттэй байдал түүний хэрэгжилтэнд хийсэн мониторинг судалгаа. 6 сар /Улаанбаатар хот, Дархан, Эрдэнэт 5 сум/ ХЭХТ, Хүнс-эвсэл ТББ тай хамтарч хийсэн Санхүүжүүлэгч ННФ Үр дүн: Олон талын хэлэлцүүлэг зохион байгуулан нөлөөллийн ажил хийсэн.</p> <p><u>Төслийн нэр:</u> “Байгаль орчны бохирдлын мэдээллийг ил тод, нээлттэй болгох” мониторинг судалгаа. 1 жил /УБ хотын Хан-Уул дүүргийн 12,13-р хороо/ Санхүүжүүлэгч: Дэлхийн нөөцийн хүрээлэн</p>

		<p>Үр дүн:Бохирдуулж байгаа болон бохирдуулах хүчин зүйлийн мэдээллийг нээлттэй, ил тод болгох, ингэснээр хяналт тавих, урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чухал ач холбогдолтой.</p>
11	<p>Тус байгууллага нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд ямар давуу талууд үзүүлэн орон нутгийн оролцогч талуудад хэрхэн чадварлаг зөвлөгч/түншлэгч байж чадах талаар тайлбарлана уу. (жишээлбэл: арга хэрэгсэл, механизм ашигласан туршлага, зорилтот бүлэгт гарсан үр нөлөө, 5 хүртэлх өгүүлбэрт бичих)</p>	<p><u>Бидэнд дараахи ажлын туршлага байгаа гэж үзэж байна.Үүнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Байгаль орчин, эрүүл мэндийн чиглэлээр төрийн болон, олон улсын байгууллагад олон жил ажиллаж, хууль, дүрэм, стандарт, журам боловсруулан, түүний хэрэгжүүлтэнд хяналт тавьж ажиллаж байсан;</li> <li>• Нийгмийн хариуцлагын талаар судалгаа, хяналт хийх, дүгнэлт үнэлгээ өгөх, мөн аргачлал, удирдамж, зөвлөгөө, заавар арга боловсруулах;</li> <li>• Нөлөөллийн төрөл бүрийн ажлууд хийх ;</li> <li>• Хичээл заах, лекц унших, зөвлөгөө өгөх, сурталчилгаа үзүүлэн таниулан хийх.</li> </ul>
12	<p>Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож/төлөвлөж буй аймаг/дүүрэг /хэрэв байгаа бол/</p>	<p>Сонирхож, төлөвлөж байгаа аймаг, дүүрэг байхгүй байна. Хөдөө орон нутагт ажиллах боломжтой.</p>
13	<p>Тус байгууллагын талаарх дээр дурьдагдаагүй нэмэлт мэдээлэл /3 хүртэлх өгүүлбэр/</p>	
14	<p>МУНЭХБ төслийн хүрээнд тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, цаашид холбоо барихыг зөвшөөрч буй эсэх талаар мэдэгдэнэ үү.</p>	

	МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	МЭДЭЭЛЭЛ
1	ТББ-ын нэр /Монгол, Англи хэл дээр/	“ <b>Бүх нийт боловсролын төлөө!</b> ” Иргэний нийгмийн үндэсний эвсэл
2	Холбогдох барих мэдээлэл/хаяг, цахим шуудан, утас, вэб хуудас, нэмэлт мэдээллийн холбоос, холбоо барих гол ажилтны мэдээлэл, хэрэв орон нутгийн салбартай бол хаяг/	Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 хороо, Нарны гудамж, Альфа цогцолбор, 302 тоот Цахим шуудан: info@all4education.mn Утас/факс: 7000-8292, 88186672 Вэбсайт: www.all4education.mn Холбоо барих: Д.Тунгалаг, утас: 99129020 coordinator@all4education.mn
3	Байгууллагын үүсгэн байгуулагдсан товч түүх	Эвслийг үүсгэн байгуулах үндсэн бүлэг 2010 оны 4-р сараас эхлэн үнэт зүйл, алсын хараа, зарчим, байр сууриа тодорхойлох, дүрэм боловсруулах үйл явцыг эхлүүлсэн. Тус оны 9-р сард Үндсэн бүлгийн 13 байгууллага үүсгэн байгуулах хурлаа хийж, дүрмээ баталснаар байгуулагдсан. Эвсэл 2012 оны 1-р сарын 26-нд Улсын бүртгэлд бүртгүүлсэн.
4	Байгууллагын тухай товч хураангуй	Эвсэл 20 гишүүн ТББ, орон нутгийн 8 салбартайгаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Хүний эрх, эмэгтэйчүүдийн болон хүүхдийн эрхийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, хүүхэд, залуусын, эцэг эхчүүд, үндэсний болон бэлгийн цөөнхийн ТББ, боловсролын асуудлаар ажилладаг ТББ, ҮЭ зэрэг байгууллагын төлөөлөлтэй. Үндэсний ба сургуулийн түвшинд боловсролын бодлого, үйл ажиллагаанд нөлөөлөх үйл ажиллагааг чанар, санхүүжилт, хариуцлага гэсэн 3 хүрээнд зохион байгуулдаг
5	Эрхэм зорилго	Иргэний нийгмийн олон салбар, нийгмийн олонлог төлөөллийг, ялангуяа үндэсний, хэлний, бэлгийн цөөнх; эмэгтэйчүүд, хүүхдүүд, залуус, ахмад үеийнхэн; хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, иргэд, хөдөө орон нутаг, гэр хорооллын иргэд зэрэг дуу хоолойгоо олон нийт, төр, засагт хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг чадваржуулах, харилцаа, хамтын ажиллагааны орон зайг бий болгох замаар тэдэнд тулгарч буй бэрхшээлийг арилгах, нөхцөл байдлыг өөрчлөх чадвартай болгон, эрх мэдлийг нь нэмэгдүүлж, боловсролын бодлого, тогтолцоог цогцоор нь шинэчлэхэд оршино.
6	Гол зорилтот бүлэг	Боловсролоос маргиналчлагдсан бүлгүүд болох хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үндэсний ба бэлгийн цөөнх хүүхэд, залуус, шийдвэр гаргагчид
7	Хүний нөөц	<b>Байгууллагын дээд удирдлага:</b> Бүх гишүүдийн чуулган. Чуулганы чөлөөт цагт 9 гишүүнтэй Удирдах зөвлөл <b>Гол гишүүд, мэргэжилтнүүд:</b> Д.Тунгалаг, зохицуулагч Б.Болорсайхан, Дэд зохицуулагч Б.Буянхишиг, захиргаа/санхүүгийн ажилтан Б.Оюунсүвд, хөтөлбөрийн ажилтан Г.Ганцэцэг, хөтөлбөрийн ажилтан

8	<b>Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулсан орон нутаг /аймаг, дүүрэг/, орон нутгийн салбарын сүлжээ</b>	<p>Эвслийн орон нутгийн салбар зөвлөл:  Баян-Өлгий, Дорноговь, Өмнөговь, Завхан, Хөвсгөл, Дорнод, УБ хотын Багануур, Налайх Дүүрэгт  Мөн төсөл хэрэгжүүлж эхэлсэн 3 аймгийн 10 сүм: Булган (Орхон, Бугат) Архангай (Өлзийт, Батцэнгэл), Хөвсгөл (Цагаан уул, Улаан уул, Цагаан нуур)</p>
9	<b>Өнгөрсөн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсрол: Мөнгө, Чанар, Хариуцлага” Иргэний нийгмийн үндэсний жил тутмын чуулган: боловсролын асуудлуудыг төр, ИНБ, иргэд, сурагч, эцэг эх олон талын төлөөлөлтэйгөөр хэлэлцдэг орон зайг бий болгох</li> <li>• Чадавх бэхжүүлэх сургалтууд: Хүний эрх, жендэрийн тэгш эрх, бодлогын дүн шинжилгээ, боловсролын төсөвт мониторинг хяналт хийх, нийгмийн аудит хийх арга зүй гэх мэт сэдвээр</li> <li>• Бүх нийтийн боловсролын чиглэлээр олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, ЗГ-тай хариуцлага тооцох чадавхийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах</li> <li>• Боловсролын зарим нэг асуудлаар гишүүн байгууллагууд судалгаа, үнэлгээ, мониторинг хийх, илтгэл бичих</li> <li>• Сургуулийн орчныг үнэлэх хамтарсан багийн “Сайн сургууль” үнэлгээний аргачлалыг УБ хот, аймгуудад хэрэгжүүлэв. Сургуулийн засаглалын орчны үнэлгээний дүнг нэгтгэн зөвлөмж боловсруулан байр суурийн баримт бичиг гаргав</li> </ul>
10	<b>Нийгмийн эгэх хариуцлага, Ил тод байдал, Сайн засаглалыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 5 хүртэлх тооны санаачилга, төсөл</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Цэцэрлэгийн эцэг хийн зөвлөлийн үйл ажиллагааг үнэлэх нь, 2013, 2014 (Баянзүрх, Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй, хан-уул дүүрэг)</li> <li>• Боловсролын санхүүжилт ба хувьчлал, 2014-2016</li> <li>• Боловсролын салбарын ил тод байдал, эгэх хариуцлага төсөл, 8 аймгийн 28 сүм, 2014-2018</li> <li>• Боловсролын засаглалыг сайжруулах нь нөлөөллийн ажил, 2013-2018, Иргэний нийгмийн боловсрол сан төсөл</li> <li>• Завхан аймагт сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэнд хийх мониторинг, 2016</li> </ul> <p><b>Хамтарч ажилласан байгууллага, хандивлагч байгууллага:</b>  Боловсролын төлөөх Дэлхийн түншлэл, Дэлхийн банкны Нийгмийн эгэх хариуцлагын дэлхийн түншлэл, Японы Хүүхдийг ивээх сан, Нээлттэй нийгэм форум, АНУ ЭСЯ, Мобилити интернейшнл, Канад сан,</p> <p><b>Гол үйл ажиллагаа, хүрсэн үр дүн тус бүрийн талаар товч нэг өгүүлбэр</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын салбарт олон талт төлөөлөл бодлогын асуудлаар байр сууриа тодорхойлдог, хэлэлцдэг болж чадавхижиж байна.</li> <li>• Боловсролын хуульд эцэг эх, сурагч, багш, олон нийтийн оролцоог шийдвэр гаргахад оролцуулах заалтууд нэмж оров.</li> <li>• Хувийн сургуульд төсвөөс олгодог санхүүжилт зохицуулалтай, хяналттай байх тухай ЗГ-ын тогтоол гарав.</li> <li>• Зорилтот аймаг, сумдад Сургуулийн эцэг эх багшийн холбоод байгуулагдаж, “Сайн сургууль” сургуулийн орчны үнэлгээг хийж эхэлснээр нийгмийн эгэх хариуцлагын механизм ажиллаж эхлэв</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Эвсэл ил тод хариуцлагатай, дотоод ардчилалтай ИНБ болж төлөвшиж байна.</li> </ul>
11	<b>Тус байгууллага нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд ямар давуу талууд үзүүлэн орон нутгийн оролцогч талуудад хэрхэн чадварлаг зөвлөгч/түншлэгч байж чадах талаар тайлбарлана уу. (жишээлбэл: арга хэрэгсэл, механизм ашигласан туршлага, зорилтот бүлэгт гарсан үр нөлөө, 5 хүртэлх өгүүлбэрт бичих)</b>	<p>Сургуулийн орчныг үнэлэх хамтарсан багийн “Сайн сургууль” үнэлгээний аргачлалыг боловсруулан хэрэгжүүлж байгаа туршлагатай.</p> <p>Энэхүү аргачлалыг Өмнөговь, Баян-өлгийн аймгийн засаг даргын тамгын газар, боловсролын газрууд авч хэрэгжүүлж байсан.</p> <p>Сургуулийн зөвхөн материаллаг орныг сайжруулаад сургалтын чанар, хүүхдийн төлөвшилд өөрчлөлт гарахгүй байгаа тул сэтгэлзүйн орчин ба засаглалын орчинд үнэлгээ хийж, асуудлуудыг олж харан шийдвэрлэдгээрээ онцлогтой.</p> <p>Бид энэхүү аргачлалыг хэрхэн хэрэгжүүлэх мэдлэг, чадварт сургадаг 2 өдрийн сургалтын хөтөлбөр, модультай.</p> <p>Үнэлгээний дараа зохион байгуулах (төсөвт хэрхэн оролцох вэ, орон нутгийн удирдлагуудтай хийх дугуй ширээний ярилцлага хэрхэн зохион байгуулах вэ гэх мэт), дэмжих үйл ажиллагааны аргачлалыг мөн боловсруулсан.</p>
12	<b>Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож/төлөвлөж буй аймаг/дүүрэг</b>	<p>УБ хотын Сонгинохайрхан дүүрэг, Сүхбаатар аймаг, Говь-Алтай, Хөвсгөл аймагтай хамтран ажиллах хүсэлтэй байна.</p> <p>Салбаргүй аймгуудад салбартай болохын төлөө ажиллана.</p>
13	<b>Тус байгууллагын талаарх дээр дурьдагдаагүй нэмэлт мэдээлэл /3 хүртэлх өгүүлбэр/</b>	<p>Боловсролын асуудлаар зөвлөлддөг механизмыг үндэсний болон бусад төвшинд байгуулах зорилготой.</p>
14	<b>МУНЭХБ төслийн хүрээнд тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, цаашид холбоо барихыг зөвшөөрч буй эсэх талаар мэдэгдэнэ үү.</b>	<p>МУНЭХБ төслийн хүрээнд тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээхийг зөвшөөрч байна.</p> <p>Бидэнтэй цаашид холбоо барихыг хөхиүлэн дэмжиж байна.</p>

	Шаардлагатай мэдээлэл	Танилцуулга
1	Байгууллагын нэр (Монгол/Англи)	<b>Транспэрэнси Интернэшнл-Монгол /</b> Transparency International-Mongolia
2	Харилцах мэдээлэл /хаяг, э-майл, утасны дугаар, вебсайт, дэлгэрэнгүй мэдээллийн холбоос, салбарын хаяг.	Оффис 1В У.А. Байр Юнэско-гийн гудамж, 30В Сүхбаатар дүүрэг 1-р Хороо Улаанбаатар 14230. <a href="http://www.transparency.mn">www.transparency.mn</a> <a href="http://www.publicwatch.mn">www.publicwatch.mn</a> Э.Мөнхжаргал , <a href="mailto:munkhjargal@transparency.mn">munkhjargal@transparency.mn</a>
3	Байгуулагдсан товч түүх	Транспэрэнси-Интернэшнл Монгол (ТИ-М) байгууллага нь анх 2003 онд олон төрийн бус байгууллагуудын төлөөлөл бүхий идэвхи санаачлагатай иргэдийн зүгээс авилгын асуудлыг зогсоох зорилгоор байгуулагдсан төрийн бус байгууллага юм. 2014 оны эхээр Транспэрэнси Интернэшнл-Глобал хөдөлгөөний албан ёсны салбараар итгэмжлэгдсэн.
4	Байгууллагын товч тайлбар	Транспэрэнси-Интернэшнл Глобал хөдөлгөөн нь Берлин хотод олон улсын нарийн бичгийн даргын газартай дэлхий даяар 100 гаруй үлс орнуудад үйл ажиллагаа явуулдаг. Мөн дэлхийд тэргүүлэх авилгын эсрэг үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бус байгууллага юм. Транспэрэнси Интернэшнл-Глобал хөдөлгөөний үндэсний салбарын хувьд Транспэрэнси Интернэшнл-Монгол нь Монгол улсад авилгын эсрэг чиглэлээр түүний хор хөнөөлийн талаар мэдлэг мэдээллийг дээшлүүлэн авилгыг зогсоох үр дүнтэй арга хэмжээнүүдийг боловсруулан хэрэгжүүлэх замаар авилгатай тэмцэх зорилгой. Үүний тулд Транспэрэнси-Интернэшнл Монгол байгууллага төрийн, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Бид иргэдийн энэхүү хичээл зүтгэлийг дэмждэгт итгэдэг ба шударга ёсны олон нийтийн шаардлага улам сайжрах ёстой. Түүнчлэн бид төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг өөрсдийн ил тод байдлаа үг болон үйлдэл дээрээ сайжруулан авилгын эсрэг бүгдэд хариуцлагатай байдлаар хангах ёстой гэж үздэг.
5	Эрхэм зорилго	Транспэрэнси Интернэшнл-Монгол байгууллагын <b>Эрхэм зорилго</b> нь авилгыг хязгаарлан ингэснээрээ шударга хариуцлагатай байдлыг дээшлүүлэж нийгмийн бүх түвшний хувь хүмүүс байгууллагуудтай хамтарч ажиллан Монгол улсын нийт хүн амд эрх тэгш байдлыг бий болгох юм.



6	<b>Үндсэн зорилтот бүлэг</b>	Төрийн үйлчилгээ хүлээн авагчид, иргэдийн сайн дурын бүлгүүд.
7	<b>Хүний нөөц</b>	Гүйцэтгэх удирдлагын нэрс: О.Батбаяр; Э.Мөнхжаргал Багийн гол гишүүд: Кристине Хүдэтц; Г.Билгүүн Б.Ану-дарь
8	<b>Үйл ажиллагааны одоогийн хамрах хүрээ /аймаг дүүрэг /, орон нутгийн салбар сүлжээ</b>	Улаанбаатар хот: гэр хорооллын 35 хороод Хөдөө орон нутагт: Увс, Баянхонгор, Өвөрхангай, Сэлэнгэ аймгууд.
9	<b>Сүүлийн 5 жилд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд</b>	Авилгын эсрэг зохион байгуулж явуулсан соён гэгээрүүлэх сургалтууд : <ul style="list-style-type: none"> <li>• Төрийн худалдан авалт ба шүүхийн системд авилгаас сэргийлэх ёрөнхий сургалт</li> <li>• Улсын мэргэжлийн хяналтын газар, Монголын хэвлэлийн хүрээлэн ба Авилгатай тэмцэх газруудад явуулсан сургалтууд</li> <li>• Улс орон даяар Шүүхийн ёс зүйн дүрмийг(2008-2009) сайжруулах шүүхийн 63 шүүгчид явуулсан сургалт</li> <li>• Их Британийн мэргэжилтнүүдийн Монгол улсын Цагдаагийн 55 удирдлагын нэгжид явуулсан сургалт</li> <li>• Их Британийн цагдаагийн хүчний дээд цолтой цагдаагийн ажилтнуудад зориулсан танилцах аялал зохион байгуулсан</li> <li>• Эрүүгийн цагдаагийн ажилчдад зориулсан “Гүйцэтгэх ажиллагаа ба мэдээллийн солилцоо” сургалт</li> <li>• Их Британы мөрдөн байцаах мэргэжилтнүүдийн АТГ-ын мөрдөн байцаагчид, прокуроруудад явуулсан “Авилгын хэргийн мөрдөн байцаалт ба Прокурорын хяналт” сургалт</li> <li>• Увс, Баянхонгор, Сэлэнгэ, Өвөрхангай аймгуудын орон нутгийн удирдлагын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллага, уул уурхайн компаниуд болон жижиг дунд үйлчдвэрлэл эрхлэгчдэд явуулсан сургалтууд</li> <li>• Хотын засаглалыг сайжруулах төслийн хүрээнд Улаанбаатар хотын удирдлага болон дүүрэг хороодын ажилтнуудад чадавхи бэхжүүлэх сургалт</li> </ul> <p>Бизнесийн шударга байдлын хөтөлбөр</p> <ul style="list-style-type: none"> <li>• Транспэрэнси-Интернэшнлийн Хээл хахуулийн эсрэг Бизнесийн зарчмын Түгээмэл хэрэглэгддэг арга барилуудын(ВРСВ) орчуулга ба хэвлүүлэлт</li> <li>• Мөн ВРСВ дээр үндэслэсэн аж ахуйн нэгжүүдийн шударга байдлыг хөгжүүлэх хөтөлбөрийн дугуй ширээний уулзалтыг зохион байгуулсан</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Монголын бизнесийн зөвлөлийн (ВСМ) дэргэд Бизнесийн ёс зүйн ажлын хэсгийг эхлүүлж хамтран даргалаж байгаа.</li> </ul> <p>Эмийн салбарын ил тод байдал</p> <ul style="list-style-type: none"> <li>• Иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллага болон эмийн салбаруудын компаниудыг хамруулсан олон оролцогч талуудын холбоог байгуулсан.</li> <li>• Иргэдийн анхан шатны эрүүл мэндийн тусламжийн хэрэгцээ шаардлагын талаар Иргэдийн Нийгмийн эрүүл мэндийн шийдвэрийг Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгтэй (МРНРА) хамтран боловсруулж улс төрийн намуудад болон хэвлэл мэдээлэлд тараасан</li> </ul> <p>Онлайн хэрэгслээр дамжуулан иргэдийн оролцоо</p> <ul style="list-style-type: none"> <li>• Иргэдэд авилгын ажиглалт туршлагаа нэрээ үл ашиглан мэдээлэх бололцоотой вебсайт, гар утасны аппликейшн болон Public watch аппликейшнуудын хөгжүүлэлж хангасан</li> <li>• Залуусыг парламентийн шийдвэр гаргах үйл явц, авилгын эсрэг сэдвүүд болон тэдний оролцоог урамшуулах гар утасны аппликейшн, Парламент Watch App уудийг хөгжүүлэн хангасан</li> </ul> <p>НҮБ-ын Авилгын эсрэг конвенцид Монгол улсын нэгдэн ороход дэмжлэг үзүүлэх бусад гол үйл ажиллагаанууд болон улс орны авилгын үнэлгээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2009 оноос хойш Транспэрэнси Интернэшнл Авилгын төсөөллийн индекс (CPI) болон Авилгын глобал барометр (Gallup International)</li> <li>• 2012 онд НҮБ-ын Авилгын эсрэг конвенцийн хэрэгжилтийн ИНБ тайлан бэлтгэсэн</li> <li>• 2015 онд 9 улс төрийн намууд хамруулсан CRINIS буюу Улс төрийн намуудын санхүүжилтийн судалгаа хийсэн.</li> <li>• Авилгын эсрэг санаачлагыг бэхжүүлэх хүрээнд хийгдсэн Монголын Авилгатай тэмцэх газрын үнэлгээ 2015-2016</li> </ul>
10	<p><b>Нийгмийн хариуцлага, ил тод байдал болон сайн засаглалыг дэмжин хэрэгжүүлсэн 5 хүртэлх санаачлага эсвэл төслийн жишээ</b></p>	<p>Төслийн нэр, хэрэгжсэн хугацаа, аймаг/сум ба дүүрэг/хороо:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хотын засаглалыг төсөл, 2015 - 2018, Улаанбаатар хотын 35 хороодод.</li> <li>2. Авилгын талаар мэдээлэх онлайн платформ <a href="http://www.publicwatch.mn">www.publicwatch.mn</a>, 2015 оноос хойш, интернэт холболттой бол хаанаас ч хэн ч орох боломжтой (нэрээ үл мэдэгдүүлэх зарчим дээр үндэслэн)</li> <li>3. Залуусыг парламентийн асуудлууд болон авилгын эсрэг сэдвүүдийн талаар мэдээллээр хангах гар утасны аппликейшн , 2015 оноос хойш, iPhone эсвэл Андроид утастай хүмүүс хаанаас ч хэзээ холбогдох бололцоотой.</li> <li>4. Эмийн ил тод байдлын холбоо, иргэдийг эмийн хариуцлага зохистой хэрэглээнд сургадаг ба тэдний эрүүл мэндийн салбарын талаар холбоотой мэдээллүүдийг дээшлүүлдэг, 2015-с оноос хойш,</li> </ol>

		<p>Улаанбаатар хотын нийт иргэдэд болон Говь-Сүмбэр, Дорнод аймгуудад хэрэгжсэн</p> <p>Хамтрагч байгууллагууд, Хандивлагч байгууллагууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Азийн сан</li> <li>• Швейцарийн хөгжлийн агентлаг</li> <li>• Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага (WHO)</li> <li>• Германы хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)</li> <li>• Канадын элчин сайдын яам</li> <li>• Английн элчин сайдын яам</li> <li>• Монголын Бизнесийн Зөвлөгөө (BCM)</li> <li>• Худалдан авах ажиллагааны газар</li> <li>• Эрүүл мэнд спортын яам</li> <li>• Азийн хөгжлийн банк (ADB)</li> </ul> <p>Үндсэн үйл ажиллагаанууд ба Хүрсэн үр дүн /үр дүн тус бүрийг нэг өгүүлбэрээр/:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үйлчилгээний хүргэлт болон туслалцаанд нийгмийн болон орон зайн тэгш бус байдлуудад чиглэж ажилласны үндсэн дээр ялангуяа гэр хорооллын эмзэг бүлгийн хүмүүст очих үйлчилгээг сайжруулсан.</li> <li>2. Иргэдэд төр засгийн харицусан байгууллагуудад авилгын ажигласан авилгын хэргээ мэдээллэх үр дүнтэй арга барилаар хангаж мөн уг асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх зөвлөгөөг өгөх бололцоогоор хангасан</li> <li>3. Улс төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаа ялангуяа парламентийн үйл явцад оролцох залуусын оролцоо сайжирсан.</li> <li>4. Худалдан авалт, чанар болон эмийн хариуцлагатай хэрэглээний талаарх иргэдийн мэдлэг мэдээлэл нэмэгдсэн.</li> </ol>
11	<p><b>Тухайн байгууллага яагаад Нийгмийн хариуцлагын арга хэрэгслүүд болон механизм, нөлөө болон зорилтот бүлгүүд зэрэгт сайн сургагч/хамтрагчын үүрэг гүйцэтгэхийг 5 хүртэлх</b></p>	<p>Берлинд Ерөнхий нарийн бичгийн газартай 100 гаруй үндэсний салбаруудын хүчин чадалтай Транспэрэнси Интернэшнл байгууллага нь Транспэрэнси-Интернэшнл Монгол байгууллагад өргөн хүрээний авилгын эсрэг арга барилууд, сайн засаглал болон хариуцлагатай байдлын арга барилуудаар хангадаг. Эдгээр боломжуудыг ашигласнаар ТИ-Монгол байгууллага нь Монгол улсад харилцаа холбооны гол хэрэгслүүдийн нэгийг ашиглан маш олон тооны иргэдэд хүрч ажиллах болно.</p>

	<b>өгүүлбэрт тайлбарлана уу.</b>	
12	<b>Аймаг дүүрэгт явуулж буй үйл ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөө эсвэл хамтран ажиллах хэтийн сонирхол хэрэв байвал</b>	Транспэрэнси Интернэшнл-Монгол байгууллага нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа голлон явуулдаг боловч Монгол улсын бүх аймгуудын ард иргэдтэй тулж ажиллах хэрэгтэй байна. Эдгээр аймгуудыг алслагдсан байдлаас шалтгаалаад тэд маш тодорхой авилгын сорилуудтай тулгарч чухал засаглал хяналтын механизмаар дутагддаг.
13	<b>Байгууллагын талаарх нэмэлт мэдээлэл /3 өгүүлбэрт багтаах/</b>	
14	<b>ТББ нь МАСАМ төслийн багийг сонирхсон орон нутгийн хамтрагч байгууллагуудад дэлгэрэнгүй мэдээллээ хуваалцах зөвшөөрөл/ баталгаа</b>	Зөвшөөрөгдсөн

	МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	МЭДЭЭЛЭЛ
1	ТББ-ын нэр /Монгол, Англи хэл дээр/	“Худалдан авах ажиллагааны түншлэл” ТББ “Public procurement partnership” NGO
2	Холбогдох барих мэдээлэл /хаяг, цахим шуудан, утас, вэб хуудас, нэмэлт мэдээллийн холбоос, холбоо барих гол ажилтны мэдээлэл, хэрэв орон нутгийн салбартай бол хаяг/	Монгол Улс, Улаанбаатар хот, ХУД, 15 хороо, Хурд хороолол 17-49 тоот, Утас 99082509(Отгонжаргал) 976-99282812 Батхуяг, Вэб: <a href="http://www.cso-pprp.com">http://www.cso-pprp.com</a> цахим шуудан: <a href="mailto:procurementpartnership@gmail.com">procurementpartnership@gmail.com</a> , <a href="mailto:b99282812@gmail.com">b99282812@gmail.com</a> ,
3	Байгууллагын үүсгэн байгуулагдсан товч түүх	2012 оны 6 сард худалдан авах ажиллагааны чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын санаачилгаар “Худалдан авах ажиллагааны түншлэл” ТББ байгуулагдаж, улсын бүртгэлд 2012 оны 07 сарын 02-нд бүртгэгдсэн. Түншлэл нь төрийн байгууллага болон аливаа улс төр, эдийн засгийн явцуу ашиг сонирхлоос хараат бус, нам бус, нийгэмд үйлчилдэг, ашгийн бус, төрийн бус байгууллага юм. Түншлэл нь худалдан авах ажиллагааны чиглэлээр дагнан мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагуудын сайн дурын, чөлөөт нэгдэл юм.
4	Байгууллагын тухай товч хураангуй	Манай байгууллага нь өнгөрсөн 4 жилийн хугацаанд түншлэгч байгууллагуудтайгаа хамтран дараахь ажил, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн юм. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Худалдан авах ажиллагаанд /ХАА/ иргэний нийгмийн оролцоог хангахад чиглэгдсэн хуулинд өөрчлөлт оруулах, төрөөс худалдан авах ажиллагааны чиглэлээр гарч буй бодлогын баримт бичигт санал өгөх (Өөрсдийн хийсэн судалгаа, ажлын түршлагад тулгуурлан хууль тогтоомжийн төсөл боловсруулах, танилцуулга хийх ажлууд хийв. Тухайлбал: Хөндлөнгийн хяналт, Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг онооны системээр үнэлэх аргачлал, Олон нийтийн оролцоотой ХАА-ны журам гэх мэт)</li> <li>• ХАА –“Нээлттэй гэрээлэлт”-н гарын авлага орчуулж холбогдох байгууллагад хүргүүлэх,</li> <li>• ХАА-ны чиглэлээр төрийн байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлэх /АЗ гэрчилгээ/</li> <li>• ХАА болон гэрээний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх /мониторинг/ УБ, Хөвсгөл, Өмнөговь, Өвөрхангай “Түргэн хожил-1, 2/ ,</li> <li>• Гадаадын хандивлагч байгууллагын дэмжлэг тусламжтайгаар өөрийн байгууллагын техник хүний нөөцийг чадавхжуулах,</li> <li>• Хөгжиж буй орнуудтай өөрийн байгууллагын түршлага хуваалцах. /Өмнөд солонгосын Гимчеон хотод “ түргэн хожил 1-2” төслийн талаар/, ХАА –ны чиглэлээр төрийн байгууллагууд, үнэлгээний хороонд оролцох, зөвлөгөө өгөх</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>Худалдан авах ажиллагааны зарчим, иргэд ба ИНБ-ын зүгээс хяналт тавих аргачлал боловсруулж иргэдэд хүргэсэн гэх мэт ажлуудыг хийж гүйцэтгэв.</li> </ul>
5	<b>Эрхэм зорилго</b>	<p>Түншлэлийн алсын хараа нь “татвар төлөгчдийн мөнгө, ард түмний баялаг зориулалтын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй зарцуулагддаг; иргэд нь төрөөс чанартай, хүртээмжтэй үйлчилгээ авах боломж бүрдсэн нийгэм” байна.</p> <p>Түншлэлийн эрхэм зорилго нь иргэдийн оролцоо, хяналтыг бий болгох замаар Засгийн газрын худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломж бүрдсэн, үр дүнтэй, хэмнэлттэй, хариуцлагатай болгоход хувь нэмрээ оруулахад оршино.</p>
6	<b>Гол зорилтот бүлэг</b>	Худалдан авах ажиллагаагаар мэргэшиж буй иргэд, байгууллагууд
7	<b>Хүний нөөц</b>	<p><b>Байгууллагын дээд удирдлага:</b> Удирдах зөвлөл (Худалдан авах ажиллагааны Тунхаг бичигт нэгдсэнээр Түншлэгч болно. Тунхаг бичгийг манай интернэт дэх хаягаас үзнэ үү.)</p> <p><b>Гол гишүүд, мэргэжилтнүүд:</b>  Тэргүүн: Отгонжаргал (Худалдан авах ажиллагааны үндэсний зөвлөх)  Удирдах зөвлөлийн гишүүд:  Батхуяг (Авто замын зөвлөх инженер, Социологич)  Жавхлан (Санхүүч, МУИС-ын багш)  Лхагва (Санхүүч, Төсвийн мэргэжилтэн асан, ИНБ-ын Хөвсгөл аймгийн манлайлагч, Түншлэлийн зохицуулагч)  Энэбиш (Түүх, нийгэм судлалын багш асан, ИНБ-ын Өмнөговь аймгийн манлайлагч, Түншлэлийн зохицуулагч)  Ганцэцэг (Эрх зүйч, ИНБ-ын Өвөрхангай аймаг дахь манлайлагч, Түншлэлийн зохицуулагч)</p>
8	<b>Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулсан орон нутаг /аймаг, дүүрэг/, орон нутгийн салбарын сүлжээ</b>	Улаанбаатар хот, Хөвсгөл, Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгууд
9	<b>Өнгөрсөн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл</b>	<ol style="list-style-type: none"> <li>Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, оролцоонд тулгуурлан ажилладаг, хариуцлагатай түншлэгч байгууллага байхын тулд чадавхиа бэхжүүлэх,</li> <li>Засгийн газрын худалдан авах ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, аудитыг хараат бус, хөндлөнгийн байр сууринаас хийх,</li> <li>Засгийн газрын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хариуцлага, үр дүнг шаардах иргэдийн чадавхийг хөгжүүлэх,</li> <li>Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, тогтолцоонд нөлөөлөх,</li> <li>Иргэд, ИНБ-уудад зориулсан худалдан авах ажиллагаа, төсвийн зарцуулалт, олон нийтийн оролцоот худалдан авах ажиллагааны зарчим, тэдгээрт тавих хяналтыг боловсронгуй болгох талаар аргачлал боловсруулж түгээх, соён гэгээрүүлэх,</li> </ol>

		6. Гэрээний хэрэгжилтэд тавих иргэдийн хяналтын олон улсын стандартыг судалж нэвтрүүлэх зэрэг болно.
10	<b>Нийгмийн эгэх хариуцлага, Ил тод байдал, Сайн засаглалыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 5 хүртэлх тооны санаачилга, төсөл</b>	<p><b>Төслийн нэр, хэрэгжүүлсэн хугацаа, хамарсан аймаг/сүм, дүүрэг/хороо:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• “ТБОНӨБАУХАТ” хуулинд худалдан авах ажиллагааны явцын болон гүйцэтгэлийн хөндлөнгийн хяналт тавих тогтолцоог бэхжүүлэх өөрчлөлт оруулсан. Тухайлбал - Явцын болон гүйцэтгэлийн хөндлөнгийн хяналт, - Эрүүл мэндийн салбарын худалдан авах ажиллагааг илүү үр ашигтай, боловсронгуй болгох зорилгоор тендерийн үнэлгээг онооны системээр хийх тухай хуульд нэмэлт оруулсан ба түүнчлэн үнэлгээний аргачлалыг Эрүүл мэндийн яам болон Сангийн яамтай хамтран, - Олон нийтийн оролцоот ХАА-ны журмын төслийг Сангийн яамтай хамтран боловсруулсан.</li> <li>• А-3 гэрчилгээ олгох сургалт зохион байгуулсан</li> <li>• “Нээлттэй гэрээ” гарын авлага орчуулж хэвлүүлсэн, СД- дээр хөрвүүлж олон нийтэд түгээсэн</li> <li>• Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл аймагуудад худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилтэд хяналт үнэлгээг гүйцэтгэсэн.</li> <li>• Гадаадын хандивлагч нарын тусламжтайгаар өөрийн байгууллагын техникийн болон хүний нөөцийг тодорхой хэмжээнд чадавхжуулсан</li> <li>• Хөгжиж буй бусад оронтой өөрсдийн туршлагаа хуваалцсан /түргэн хожил” төслийн хүрээнд Вьетнам, Лаос, Индонез, филиппин, Мьяамар, Унгар гм/ “Түргэн хожил” -1, “Түргэн хожил” -2, төсөл, 12 сар, Улаанбаатар, Хөвсгөл, Өмнөговь, Өвөрхангай аймаг</li> <li>• Их британи улсын КОСТ буюу “Барилга угсралтын салбарын ил тод байдал” стандартыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг ханган, хамтран ажиллахаар тохиролцоонд хүрсэн, уг стандартыг Монгол Улсад нэвтрүүлэхэд шаардагдах санхүүжилт хайж байгаа зэрэг болно.</li> </ul> <p><b>Хамтарч ажилласан байгууллага, хандивлагч байгууллага:</b> УИХ, Засгийн газар, Сангийн яам, Зам, тээврийн яам, Орон нутгийн засаг даргын тамгын газар, Иргэдийн хурал болон Дэлхийн банк, АХБ, Швейцарийн хөгжлийн агентлаг зэрэг олон улсын байгууллагууд</p> <p><b>Гол үйл ажиллагаа, хүрсэн үр дүн тус бүрийн талаар товч нэг өгүүлбэр</b> Орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулахад иргэний нийгмийн оролцоог хангах чиглэлээр тендерийн үнэлгээний хороонд иргэний нийгмийн төлөөлөл оруулдаг болсон, сонгон шалгаруулалтыг илүү нээлттэй болгож мэдээллийг олон нийтийн сүлжээгээр мэдээлдэг болсон, төрийн байгууллагууд иргэний нийгмийн байгууллагуудтайгаа хамтран ажиллах ялангуяа худалдан авах ажиллагааны төлөвлөлт, явцын болон гүйцэтгэлийн хяналт тавих байдлыг сайшаан дэмжиж цаашид илүү өргөн хүрээнд хамтран ажиллах идэвхи санаачлагатай болсон. Орон нутагт төрийн байгуулагаас гаргаж байгаа шийдвэр иргэний нийгмийн оролцоог хангах талаар чармайлт гаргадаг болсон. Түншлэгч байгууллагууд маань илүү чадавхижиж, тэдний оролцооны үүрэг, ач холбогдлыг холбогдох төрийн байгууллагууд үнэлж ойлгон, хамтран ажиллах соёл тогтож чадсан.</p>
11	<b>Тус байгууллага нийгмийн эгэх</b>	Манай байгууллага нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд дараах давуу талууд үзүүлэн зөвлөгч болж чадна.

	<p><b>хариуцлагыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд ямар давуу талууд үзүүлэн орон нутгийн оролцогч талуудад хэрхэн чадварлаг зөвлөгч/түншлэгч байж чадах талаар тайлбарлана уу. (жишээлбэл: арга хэрэгсэл, механизм ашигласан туршлага, зорилтот бүлэгт гарсан үр нөлөө, 5 хүртэлх өгүүлбэрт бичих)</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• 2011 онд манай байгууллагын манлайлагчдын оролцоотойгоор Худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжид томоохон өөрчлөлтүүд орсон.</li> <li>• Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр 60 орчим иргэний нийгмийн байгууллагууд Засгийн газартай хамтран төрийн Худалдан авах үйл ажиллагааг хянах, тендерийн явцыг үнэлэхэд иргэний нийгмийн оролцоо, үүргийг хууль эрх зүйн хүрээнд бий болгож чадсаны хувьд худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн хүний нөөцтэй.</li> <li>• Худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээг /мониторинг/ Улаанбаатар болон хөдөө орон нутагт хийсэн туршлагатай.</li> <li>• Эрх зүйн орчин /мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль, төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль, төсвийн тухай хууль/ нь иргэний нийгмийн байгууллагууд төрийн байгууллагатай хамтран ажиллах илүү боломжтой</li> <li>• Худалдан авах ажиллагааны талаар цахим сүлжээ, портал сайтуудаад дамжуулж хамтын ажиллагаа түргэн шуурхай, нээлтэй шудрага явуулах боломжтой.</li> </ul>
12	<p><b>Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож/төлөвлөж буй аймаг/дүүрэг /хэрэв байгаа бол/</b></p>	<p>Ховд, Сэлэнгэ, Дорнод, Дундговь</p>
13	<p><b>Тус байгууллагын талаарх дээр дурьдагдаагүй нэмэлт мэдээлэл /3 хүртэлх өгүүлбэр/</b></p>	<p>Манай байгууллага дараахь төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж хамтран ажиллах саналтай байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ухаалаг засаглал</li> <li>• Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал</li> <li>• Төсвийн зарцуулалтын ил тод байдал</li> <li>• 80 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй төсвийн худалдан авалтын гэрээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар хэрэгжүүлэх</li> <li>• Төрийн шийдвэрт иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх</li> <li>• Нэг цонхны үйлчилгээ</li> <li>• 11-11 төв</li> <li>• Төрийн захиргааны үйлчилгээний нэгдсэн стандарт бий болгох</li> <li>• Шилэн дансны тухай хууль болон Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт</li> <li>• Нээлттэй Засаглалын Түншлэлийн амлалтууд</li> <li>• Олон улсын стандартууд, тэргүүн туршлага бүхий төсөл хөтөлбөр</li> </ul>
14	<p><b>МУНЭХБ төслийн хүрээнд тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, цаашид холбоо барихыг зөвшөөрч буй</b></p>	<p>МУНЭХБ төслийн хүрээнд манай байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, цаашид холбоо барихыг зөвшөөрч байгааг үүгээр мэдэгдэж байна.</p> <p>Бид уг төслийг Говьсүмбэр, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгуудад өөрсдийн Түншлэгч байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх саналтай байна.</p>



**эсэх талаар мэдэгдэнэ  
үү.**

**ТЭРГҮҮН Н.ОТГОНЖАРГАЛ,  
2016 оны 6 дугаар сар 14**

	МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	МЭДЭЭЛЭЛ
1	ТББ-ын нэр /Монгол, Англи хэл дээр/	<p>1) <b>Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо</b> ТББ</p> <p>2) Хамтран ажиллах байгууллага: “Сайн дурынхны хөгжлийн төв” ТББ</p>
2	Холбогдох барих мэдээлэл /хаяг, цахим шуудан, утас, вэб хуудас, нэмэлт мэдээллийн холбоос, холбоо барих гол ажилтны мэдээлэл, хэрэв орон нутгийн салбартай бол хаяг/	<p>1) Улаанбаатар хот, ХУД 2-р хороо Гутал ХХК-ийн байр 03 тоот Email: <a href="mailto:mawu.mtih@yahoo.com">mawu.mtih@yahoo.com</a> <a href="mailto:chuluundolgor@gmail.com">chuluundolgor@gmail.com</a> <a href="http://www.facebook.com/MNAWU/">www.facebook.com/MNAWU/</a> Холбоо барих утас: 89982929/75952929 Баянхонгор аймгийн Тэргэнцэртэй Иргэдийн Холбоо: Мөнхсаруул 89901014 Архангай аймгийн Тэргэнцэртэй Иргэдийн Холбоо: М. Мэндсайхан 96610738 Өвөрхангай аймгийн Тэргэнцэртэй Иргэдийн Холбоо: Ш. Самдан 99048630 Хөвсгөл аймгийн Тэргэнцэртэй Иргэдийн Холбоо ДарханУул амийгийн Тэргэнцэртэй иргэдийн холбоо 3. Зоригоохүү 99791896</p> <p>2) Улаанбаатар хот, БГД 2-р хороо, Гранд плаза-804 тоот Email: <a href="mailto:vdcenter.ngo@gmail.com">vdcenter.ngo@gmail.com</a> <a href="http://www.facebook.com/Сайн-дурынхны-хөгжлийн-төв/">www.facebook.com/Сайн-дурынхны-хөгжлийн-төв/</a> Холбоо барих утас: 99019645</p>
3	Байгууллагын үүсгэн байгуулагдсан товч түүх	<p>1) Анх 14 тэргэнцэртэй иргэний үүсэл санаачлагаар 2005 онд Тэргэнцэртэй иргэдийг дэмжих холбоо нэртэйгээр үүсгэн байгуулагдаж байсан. Тухайн үед харааны бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй иргэд өөрсдийн эрх ашгийг хамгаалах байгууллага байгуулж амжилттай ажиллаж байгааг хараад бид ч гэсэн өөрсдийнхөө эрхийн төлөө хамтдаа тэмцэх ёстой гэж шийдсэн</p> <p>2) 2009 онд залуучуудын үүсгэл санаачлагаар байгуулагдсан. Байгууллага нь нийгмийн бүхий л салбарт сайн дурынхны оролцоо, хувь нэмрийг нэмэгдүүлэх үндсэн зорилготой.</p>
4	Байгууллагын тухай товч хураангуй	<p>1) Манай байгууллага 2007 онд Тэргэнцэртэй иргэдийн холбоо болон нэрээ өөрчилж, залуучууд УЗГ-ээр орж эхэлж ажиллаж байсан бол 2011 онд үйл ажиллагаа тэлж үндэсний хэмжээнд ажиллах нь зүйтэй гэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэр гарсан тул Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо болон өргөжсөн . Холбооны удирдах дээд байгууллага нь 4 жил тутамд хуралдах бүх гишүүдийн хурал бөгөөд бүх</p>

		<p>гишүүдийн хурлаас холбооны УЗГ-дийг 9 хүний бүрэлдэхүүнтэй сонгодог. Мөн бүх гишүүдийн хурлаас хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй сонгодог. Хяналтын зөвлөл нь удирдах зөвлөлийн үйл ажиллаанд хяналт тавьдаг. Удирдах зөвлөлөөс ажлын албадуудыг томилон үйл ажиллагааны төлөвлөлт хэрэгжилтийг хянаж ажилладаг.</p> <p>2) Байгууллага нь 2009 онд байгуулагдсан хэдий ч үйл ажиллагаагаа тогтмол явуулаагүй байсан Одоо 2016 оноос үйл ажиллагаагаа тогтмолжуулан ажиллахаар зорилго тавин ажиллаж байна.</p>
5	<b>Эрхэм зорилго</b>	<b>Тэгш оролцоот хүртээмжтэй нийгэм</b>
6	<b>Гол зорилтот бүлэг</b>	Нийгмийн эмзэг бүлэг /үүнд: хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүд, өрх толгойлсон эцэг, эхүүд, ажилгүй залуучууд/
7	<b>Хүний нөөц</b>	<p><b>Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо ТББ-ын дээд удирдлага: Бүх гишүүдийн хурал</b></p> <p>Б.Чулуундолгор - Тэргүүн Гол гишүүд, мэргэжилтнүүд: УЗГ-үүдийн 50% -нь ажлын албадуудад хувиарлагдан ажилладаг. Мөн мэргэжлийн нийгмийн ажилтан, санхүүгийн ажилтантай. Сайн дурын дэмжигч, туслагч гишүүд ажилладаг.</p> <p><b>Сайн дурынхны хөгжлийн төв ТББ:</b></p> <p>М.Бямбабат- Гүйцэтгэх захирал Идэвхтэн, сайн дурын гишүүдтэй.</p>
8	<b>Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулсан орон нутаг /аймаг, дүүрэг/, орон нутгийн салбарын сүлжээ</b>	Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны гишүүд нь УБ хотын 9 дүүрэгт ажиллаж амьдардаг тул холбоо Нийслэлийн 9 дүүргийг хамран үйл ажиллагаагаа явуулж чаддаг. Мөн салбар зөвлөлүүд ажиллаж байгаа Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Хөвсгөл, Дархан-Уул аймгуудад хүрч ажилладаг Манай байгууллага нь ХАХНХЯ-ны ХБИ-н бодлогын зөвлөл, БХБЯ-ны сайдын зөвлөл, ХЯ-ны ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөл, БШУЯ-ны ХБИ-ийн боловсролын зөвлөл, ЭМСЯ-ны иргэний нийгмийн зөвлөлд тус тус орж ажилладаг тул зарим үйл ажиллагаа зөвхөн салбар зөвлөлтэй аймгуудаар хязгаарлагдахгүй бүх орон нутгийг хамран хэргэждэг
9	<b>Өнгөрсөн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл</b>	<p><b>1. ХБИ-дэд Хүртээмжтэй үйлчилгээг бий болгох</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Тэргэнцэр засварын төв</li> <li>• Wheelchair Taxi үйлчилгээ</li> <li>• Эмнэлгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох үнэлгээ, мониторинг, санал, хэлэлцүүлэг бодлогын нөлөөлөл</li> </ul> <p><b>2. ХБИ-дэд Хүртээмжтэй орчныг бий болгох</b></p>

		<ul style="list-style-type: none"> <li>• Дэд бүтцийн хүртээмжинд үнэлгээ хийх баг бий болгож, үнэлгээний аргачилалыг боловсруулан гаргасан</li> <li>• Барилгын хөгжлийн төвтэй хамтран Мэргэшсэн архитекторуудын мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа жилд 250 архитекторч</li> <li>• Барилга хүлээж авах Улсын комисст төлөөлөлөө оруулсан</li> </ul> <p><b>3. Гишүүд болон байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Тэгш оролцоо сургалтын төв</li> <li>• Залуучуудын хөтөлбөр</li> <li>• Эмэгтэйчүүдийн хөтөлбөр</li> <li>• Гар урлалын төв</li> </ul> <p><b>4. Бодлогын нөлөөлөл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• ХБХ-ийн Эрхийн тухай хуулийг боловсруулж батлуулах</li> <li>• ХБХ-ийн эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулж батлуулах</li> <li>• ХБХЭТК болон бусад ОУ-ын гэрээ конвенцуудад тусгагдсан ХБХ-ийн Эрхийн хэрэгжилт ямар байгаад хяналт үнэлгээ хийж, ОУ-ын Хүний эрхийн байгууллагуудад мэдээлэх, сүүдрийн илтгэл бичих</li> </ul>
10	<p><b>Нийгмийн эгэх хариуцлага, Ил тод байдал, Сайн засаглалыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 5 хүртэлх тооны санаачилга, төсөл</b></p>	<p>Төслийн нэр, хэрэгжүүлсэн хугацаа, хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Явган хүний зам -2012-2014 -УБ хотын 9 дүүрэг</li> <li>2. ХБХ-ийн Сонгуулийн оролцооны үнэлгээ -2012-УБ хотын ХУД, СХД, БГД, Архангай, Өвөрхангай, Увс, Баянхонгор, Дархан-Уул аймгууд</li> <li>3. Сайн сургууль үнэлгээ 2013-УБ хотын 63-р сургууль</li> <li>4. ЗГ-ын байруудын орчны хүртээмжийн үнэлгээ -2014</li> <li>5. 1,2-р шатлалын эмнэлэгүүдийн орчны хүртээмжийн үнэлгээ</li> <li>6. ХБ-тэй эмэгтэйчүүдэд хүрэх НҮЭМ-н үйлчилгээг сайжруулах</li> </ol> <p><b>Хамтарч ажилласан байгууллага, хандивлагч байгууллага:</b> Дэлхийн банк, Мерси Кор ОУБ, Нээлттэй нийгэм форум, Хотын захиргаа, Канад сан, Боловсрол эвсэл</p> <p>Гол үйл ажиллагаа, хүрсэн үр дүн тус бүрийн талаар товч нэг өгүүлбэр</p> <ol style="list-style-type: none"> <li>1. ИОК-аар үнэлгээ хийж сайжруулах санал зөвлөмжийн төрийн байгууллагт хүргэсэнээр асуудал сайжирсан.</li> </ol>

		<ol style="list-style-type: none"> <li>2. ХБХ-ийн сонгуулийн оролцоо ямар байгаа, ямар асуудал шалтгаан байгаа болон санал авах байрнуудын хүртээмжийн байдалд үнэлгээ хийж тайланг, дүгнэлт зөвлөмжийн хамт гаргасанаар Сонгуулийн хуулинд 3 заалт оруулсан.</li> <li>3. Сургуулийн орчин, үйлчилгээ, удирдлагын үйл ажиллагаанд үнэлгээ хийж, асуудлыг сайжруулах төлөвлөгөөг сургуулийн захиргаатай хамтран гаргаж хэрэгжүүлсэнээр асуудал багассан.</li> <li>4. Үнэлгээний дүнг ЭМСЯ болон ДЭМБ-т танилцуулж хүргүүлсэн, 2016 оноос эхлэн эмнэлэгүүдийн төсөвт хүртээмжтэй болгох зардалууд тусгагдаж эхэлж байгаа.</li> <li>5. Хэрхэн хүртээмжтэй эмнэлэгийн үйлчилгээ орчинг бүрдүүлэх тухай гарын авлагыг орчуулан хэвлэж 21 аймаг 9 дүүрэгт хүргэсэн.</li> </ol>
11	<p><b>Тус байгууллага нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд ямар давуу талууд үзүүлэн орон нутгийн оролцогч талуудад хэрхэн чадварлаг зөвлөгч/түншлэгч байж чадах талаар тайлбарлана уу. (жишээлбэл: арга хэрэгсэл, механизм ашигласан туршлага, зорилтот бүлэгт гарсан үр нөлөө, 5 хүртэлх өгүүлбэрт бичих)</b></p>	<p>Бид нийгмийн цөөнх болох хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн эгэх хариуцлагын талаарх мэдлэг ойлголтыг түгээх, бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. Үйл ажиллагааг зохион байгуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрсдийнх нь оролцоонд тулгуурлахдаа анхаарна.</p> <p>Манай байгууллага нь УБ хотын 9 дүүрэг болон Архангай, Дархан-Уул, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл болон Хэнтий, Увс аймгуудад байгаа өөрийн салбар зөвлөлүүд болон идэвхтэй гишүүддээ Нийгмийн эгэх хариуцлагын мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлж, улмаар манай үндсэн үйл ажиллаганы нэг болох үйлчилгээний байгууллагуудын орчин, үйлчилгээ, бодлогт ХБ-тэй иргэдийн асуудал хэрхэн тусгагдаж байгаад үнэлгээ хийж, засаж сайжруулах нөлөөллийн үйл ажиллагааг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх арга ажиллагаа, туршлагаа хуваалцах болно.</p>
12	<p><b>Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож/төлөвлөж буй аймаг/дүүрэг /хэрэв байгаа бол/</b></p>	<p>Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Дархан-Уул, Хөвсгөл, Хэнтий аймгуудийн салбар холбоогоо бэхжүүлэх, мөн Ховд, Дундговь, Сэлэнгэ, Увс аймгуудад салбар холбоог байгуулахаар зорьж байгаа.</p>
13	<p><b>Тус байгууллагын талаарх дээр дурьдагдаагүй нэмэлт мэдээлэл /3 хүртэлх өгүүлбэр/</b></p>	<p>МЭХБ талаарх манай санал, санаачлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>• ХБ-тэй хүмүүсийн төрийн үйлчилгээтэй холбоотой санал, гомдлыг сонсох, мэдээлэл цуглуулах “Call center” /Санал, гомдол хүлээн авах дуудлагын утас ажилуулах төв/-ийг үүсгэн байгуулахаар ажиллаж байна. Энэ ажил нь орон зайг үл хамраах тул бидний хувьд хамгийн тохиромжтой мэдээлэл цуглуулах, түгээх арга байх болно. Бид энэ үйл ажиллагаагаа МУНЭХ-ийн төсөлтэй үялдуулах зорилготой байгаа.</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Мөн төрийн үйлчилгээ хүрч чадахгүй байгаа нийгмийн бусад бүлгүүдийн иргэдийг чадваржуулах, мэдээлжүүлэх замаар эдгээр бүлгийн иргэдийг төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх тэдний дуу хоолой, оролцоог нэмэгдүүлж ажиллана.</li> </ul> <p>Хамтран ажиллах байгууллагуудын тухайд          Аль аль байгууллага нь тухайн асуудлаа мэддэг, чадвартай боловсон хүчинтэй.</p>
14	<p><b>МУНЭХБ төслийн хүрээнд тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, цаашид холбоо барихыг зөвшөөрч буй эсэх талаар мэдэгдэнэ үү.</b></p>	<p>Зөвшөөрөл өгч байна</p>

	МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	МЭДЭЭЛЭЛ
1	ТББ-ын нэр /Монгол, Англи хэл дээр/	<b>МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ</b> ТББ MONFEMNET National Network
2	Холбогдох барих мэдээлэл /хаяг, цахим шуудан, утас, вэб хуудас, нэмэлт мэдээллийн холбоос, холбоо барих гол ажилтны мэдээлэл, хэрэв орон нутгийн салбартай бол хаяг/	Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Пума 56/2-5 Имэйл: <a href="mailto:manager@monfemnet.org">manager@monfemnet.org</a> / <a href="mailto:info@monfemnet.org">info@monfemnet.org</a> Вэб хуудас: <a href="http://www.monfemnet.org">www.monfemnet.org</a> Утас: 7011-0355 Ерөнхий зохицуулагч Д.Энхжаргал ( <a href="mailto:coordinator@monfemnet.org">coordinator@monfemnet.org</a> ) Хөтөлбөрийн менежер А.Саранцэцэг ( <a href="mailto:manager@monfemnet.org">manager@monfemnet.org</a> )
3	Байгууллагын үүсгэн байгуулагдсан товч түүх	МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ нь Монголын эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын V чуулганы шийдвэрээр 2000 онд байгуулагдсан. Үйл ажиллагаагаа илүү өргөн хүрээтэй, үр дүнтэй болгох зорилгоор цар хүрээгээ тэлсэнтэй холбогдуулж, 2007 оны чуулганаар дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулж, эмэгтэйчүүдийн хүний эрх, жендэрийн тэгш эрх, нийгмийн шударга ёсны төлөө ажиллах болсон.
4	Байгууллагын тухай товч хураангуй	МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ нь хүний эрхийг хангах, жендэрийн шударга ёс, ардчиллын хэм хэмжээг төлөвшүүлэх зорилготой, 21 гишүүн байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн, нам бус, ашгийн бус, төрийн бус байгууллага.
5	Эрхэм зорилго	Нийгмийн бүх хүрээг хамарсан, олон нийтийн өргөн оролцоотой, ардчилсан, нээлттэй, зоримог, түүштай, жендэрийн тэгш эрх, шударга ёсны төлөө үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх хүч болох
6	Гол зорилтот бүлэг	Жендэр, нас, шашин шүтлэг, угсаа гарал, газарзүйн байршил, бэлгийн баримжаа, нийгмийн статус, арьсны өнгө зэргээс үл хамааран хүн бүрийн төлөө
7	Хүний нөөц	Байгууллагын дээд удирдлага: - Бүх гишүүдийн хурал - Удирдах зөвлөл (7 хүний бүрэлдэхүүнтэй) - Дүрмийн хороо Гол гишүүд, мэргэжилтнүүд: - Ерөнхий зохицуулагч Д.Энхжаргал - Хөтөлбөрийн менежер А.Саранцэцэг - Хөтөлбөр /Гадаад харилцааны ажилтан Ш.Саранхөхөө - Хөтөлбөр/Захиргааны ажилтан Д.Должинсүрэн - Санхүү/Захиргааны ажилтан Т.Наранцэцэг
8	Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулсан орон нутаг /аймаг, дүүрэг/, орон	- 21 аймаг, 9 дүүрэгт

	нутгийн салбарын сүлжээ	
9	Өнгөрсөн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл	<ul style="list-style-type: none"> <li>- Бодлогын дүн шинжилгээ, хэрэгжилтийн үнэлгээ</li> <li>- Бодлогод нөлөөлөх;</li> <li>- Олон нийтийн чөлөөт индэр болох;</li> <li>- Олон нийтийн оролцоог дайчлах аргачлалыг хөгжүүлэх;</li> <li>- Хамтын манлайллыг хөгжүүлэх.</li> </ul>
10	Нийгмийн эгэх хариуцлага, Ил тод байдал, Сайн засаглалыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 5 хүртэлх тооны санаачилга, төсөл	<p>Төслийн нэр, хэрэгжүүлсэн хугацаа, хамарсан аймаг/сүм, дүүрэг/хороо:</p> <p>1. “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” ИТХ-ын эмэгтэй төлөөлөгч нарт зориулагдсан манлайллын сургалт</p> <ul style="list-style-type: none"> <li>- Манлайллын тухай одоогийн ойлголт</li> <li>- Хэнийг төлөөлөх вэ? Нийгмийн бүтцийн зураглал</li> <li>- Тулгамдсан асуудлыг тодорхойлох, шинжлэх</li> <li>- Эрх мэдлийн хуваарилалтыг шинжлэх</li> <li>- Эмэгтэйчүүдийн төлөөлөл ба ардчилал</li> <li>- Нийтийн сайн сайхны төлөө: Хамтын манлайлал</li> <li>- Стратегитайгаар төлөвлөх</li> <li>- Нөлөөллийн хүрээгээ бэхжүүлэх</li> </ul> <p><b>21 аймаг, 9 дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч эмэгтэйчүүдийг хамруулсан төсөл</b></p> <p>2. Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, нөлөөллийн чадавхыг бэхжүүлэх төсөл</p> <p><b>21 аймаг, 9 дүүргээс Нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийг чадавхжуулах сургалт</b></p> <p>3. SASA! Олон нийтийн оролцоог дайчлах аргачлалыг хөгжүүлэх сургалт (2011 оноос хойш зохион байгуулагдаж байгаа)</p> <ul style="list-style-type: none"> <li>- Баян-Өлгий - Баянхонгор</li> <li>- Говь-Алтай - Дархан-Уул</li> <li>- Дорноговь - Дорнод</li> <li>- Завхан - Орхон</li> <li>- Өвөрхангай - Өмнөговь</li> <li>- Увс - Ховд</li> <li>- Улаанбаатар</li> </ul> <p>4. “Аюулгүй сургууль” Сургуулийн сайн засаглалыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх аргачлал.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Баян-Өлгий</li> <li>- Завхан</li> <li>- Өмнөговь</li> <li>- Чингэлтэй дүүрэг</li> </ul> <p>5. “Эмэгтэйчүүдийн нүдээр” чуулган сүүлийн 11 жил тасралтгүй зохион байгуулж байна.</p>



		<p>“Залуу эмэгтэйчүүдийн дуу хоолой” форум 7 жил тасралтгүй зохион байгуулж байна.</p> <p>- Үндэсний хэмжээнд</p> <p>5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх түгээмэл эрхийн хэрэгжилтийн талаар Монгол Улсад нөхцөл байдлын үнэлгээ хийсэн.</p> <hr/> <p>Хамтарч ажилласан байгууллага, хандивлагч байгууллага: Хандивлагч байгууллага</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр</li> <li>2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан</li> <li>3. АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын Эмэгтэйчүүдийн асуудлын сан</li> <li>4. Швейцарийн хөгжлийн агентлаг</li> <li>5. Ази Номхон далайн бүсийн эмэгтэйчүүдийн мэдээлэл судалгааны төв (ARROW)</li> </ol> <p>Хамтарч ажилласан</p> <ol style="list-style-type: none"> <li>6. Монгол Улсын Их Хурлын (УИХ) Тамгын газар</li> <li>7. Хүүхэд гэр бүл хөгжлийн төвийн дэргэдэх Залуучууд хөгжлийн төв (11 аймаг, 3 дүүрэг)</li> <li>8. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв</li> <li>9. “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл</li> <li>10. SASA! активистуудын сүлжээ</li> </ol> <hr/> <p>Гол үйл ажиллагаа, хүрсэн үр дүн тус бүрийн талаар товч нэг өгүүлбэр</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалтыг 21 аймаг, 9 дүүргийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгч нарт зориулан зохион байгуулсан. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдон ажиллаж байгаа эмэгтэй төлөөлөгчдөд хамтын манлайллын үр чадваруудыг эзэмшүүлж, нөлөөллийн чадавхийг дээшлүүлж, эмэгтэйчүүдийн улс төрийн тэгш, үр дүнтэй, утга учир бүхий оролцоо, шударга төлөөллийг нэмэгдүүлэх талаар стратеги, тактикийн үр чадвар эзэмшсэн.</li> <li>2. "Эмэгтэйчүүдийн нүдээр" 10-р чуулган, "Залуу эмэгтэйчүүдийн дуу хоолой" 6-р форумын оролцогчдын Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой уулзаж, байр суурийн баримт бичиг, зөвлөмжийг өргөн барьсан. Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч хууль санаачлах бүрэн эрхийнхээ хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг УИХ-д яаралтай өргөн барихаа мэдэгдсэн юм. Ингэснээр гацаанд байсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль энэ хаврын чуулганаар батлагдсан.</li> <li>3. “SASA! Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг орон нутагуудад зохион байгуулснаар</li> </ol>
--	--	--

		2013-2014	Check My School: ЕБС-ийн ил тод байдал, хүртээмж	6 дүүргийн 12 ЕБС	14,399 сурагч, эцэг эх
		2013	Check My Clinic: Өрхийн эрүүл мэндийн төвийн ил тод байдал, хүртээмж	ЧД-ийн 6, 16-р хорооны ӨЭМТ	1,730 үйлчилгээ хүртэгч иргэн
		2013-2014	Check My Hospital: Дүүргийн ЭМН-ийн ил тод байдал, хүртээмж	БГД, ЧД-ийн Эрүүл мэндийн төв	2,840 үйлчилгээ хүртэгч иргэн
		2014	Check My Hospital-1: Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэгийн ил тод байдал, үйлчилгээний хүртээмж	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг	3,468 үйлчилгээ хүртэгч иргэн
		2014	Check My Local Service: Орон нутгийн төрийн үйлчилгээний ил тод байдал, хүртээмж	6 аймаг, 14 сум, 3 хорооны 17 үйлчилгээ үзүүлэгч байгууллага	3,221 үйлчилгээ хүртэгч иргэн
		2015	Check My UB Service: Нийслэлийн нутгийн удирдлагын байгууллагын үйлчилгээний ил тод байдал, хүртээмж	5 дүүргийн 26 үйлчилгээ үзүүлэгч байгууллага	10,506 үйлчилгээ хүртэгч иргэн

		2015-2016	Check My Khoroo: 6 дүүргийн 12 хорооны 21 үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хүртээмж	6 дүүргийн 12 хорооны 21 үйлчилгээ үзүүлэгч байгууллага	5,505 үйлчилгээ хүртэгч иргэн	
<p><b>Хамтарч ажилласан байгууллага, хандивлагч байгууллага:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ 84 үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллага</li> <li>▪ 43,748 үйлчилгээ хүртэгч иргэн</li> <li>▪ 5 хандивлагч байгууллага</li> </ul>						
<p><b>Гол үйл ажиллагаа, хүрсэн үр дүн тус бүрийн талаар товч нэг өгүүлбэр</b></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ ДЕМО-ийн ИОК-ын үнэлгээний үр дүнд төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшин огцом сайжирсан: өмнө нь энэ байгууллагууд МИТБМАЭ тухай хуулийн талаар ямар ч ойлголтгүй байсан бол давтан үнэлгээгээр бүх байгууллагууд тус хуулийг хэрэгжүүлдэг болсон.</li> <li>▪ ДЕМО-ийн үнэлгээнд хамрагдсан иргэд ИОК-ын аргачлал, багаар ажиллах, мэдээлэл цуглуулах, хууль дүрэм судлах зэрэг чадвар эзэмшихээс гадна аливаа зүйлийг баримт нотолгоон дээр суурилан ярих хандлагатай болж өөрчлөгддөг.</li> <li>▪ ИОК-ын үнэлгээний үр дүнд гаргадаг Үйлчилгээг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 70-100 хувьтай.</li> </ul> <p><u>ИОК-ын үнэлгээнд хамрагдсан салбар/үйлчилгээ:</u></p> <p>Боловсролын салбар:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ 8 цэцэрлэг</li> <li>▪ 24 ерөнхий боловсролын сургууль</li> <li>▪ 3 их сургууль</li> </ul> <p>Эрүүл мэндийн салбар:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ 10 өрхийн эрүүл мэндийн төв</li> <li>▪ 5 дүүргийн Эрүүл мэндийн төв, салбар амбулатори</li> <li>▪ 1 улсын нэгдүгээр төв эмнэлэг</li> </ul> <p>Дэд бүтэц:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Нийтийн тээвэр, Худаг, Тог цахилгаан, Хог хаягдал, Гудамжны гэрэлтүүлэг, Газар зохион байгуулалт, Камержуулалт, Хаягжилт, Нүхэн жорлон, угаадасны нүх</li> </ul> <p>Бусад:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын үйлчилгээ</li> <li>▪ Нийслэлийн Иргэдэд үйлчилгээ үзүүлэх төв</li> <li>▪ СБД-ийн 9-р хорооны нийгмийн халамж</li> </ul>						

11	<p><b>Тус байгууллага нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд ямар давуу талууд үзүүлэн орон нутгийн оролцогч талуудад хэрхэн чадварлаг зөвлөгч/түншлэгч байж чадах талаар тайлбарлана уу. (жишээлбэл: арга хэрэгсэл, механизм ашигласан туршлага, зорилтот бүлэгт гарсан үр нөлөө, 5 хүртэлх өгүүлбэрт бичих)</b></p>	<p><b>ДЕМО нь дараах үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх боломжтой, туршлагатай. Үүнд:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Орон нутгийн төрийн үйлчилгээний СУУРЬ ҮНЭЛГЭЭГ хийж гүйцэтгэх</li> <li>2. Орон нутгийн ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ ИРГЭДИЙН ОНООНЫ КАРТЫН АРГАЧЛАЛААР ҮНЭЛЭХ</li> <li>3. Төрийн байгууллагуудтай БҮТЭЭЛЧЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ</li> <li>4. Дараах сэдвээр ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТУУД: <ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн хариуцлагын үзэл баримтлал, үндсэн ойлголт</li> <li>- Иргэдийн онооны картын аргачлал</li> <li>- Төсвийн үйл явцад иргэдийн оролцоо</li> <li>- Иргэдийн оролцоо</li> <li>- Бодлогын нөлөөлөл хийх үр чадвар /зэрэг бусад сэдвүүд/</li> </ul> </li> <li>5. Нийгмийн хариуцлагын чиглэлээр ЗӨВЛӨГӨӨ, МЕНТОРИНГ буюу СУРГАН ЧИГЛҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</li> </ol>
12	<p><b>Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож/төлөвлөж буй аймаг/дүүрэг /хэрэв байгаа бол/</b></p>	<p>ДЕМО нь аль ч аймаг, дүүрэгтэй хамтран ажиллахад нээлттэй.</p>
13	<p><b>Тус байгууллагын талаарх дээр дурьдагдаагүй нэмэлт мэдээлэл /3 хүртэлх өгүүлбэр/</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>▪ ДЕМО-ийн Check My Service санаачлага нь Авлигатай тэмцэх газраас 2013 оны шилдэг туршлагаар шалгарч “Шудрага ёсны төлөө” өргөмжлөл хүртсэн.</li> <li>▪ 2015 онд Мексикт болсон НЗТ-ийн дэлхийн өндөр түвшний чуулганд уригдаж Check My Service санаачлагаа танилцуулсан.</li> <li>▪ БШУЯ-тай хамтран ЕБС-ийн ил тод байдал, хүртээмжийг ИОК-ын аргачлалаар үнэлэх журмын төслийг боловсруулсан.</li> </ul>
14	<p><b>МУНЭХБ төслийн хүрээнд тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, цаашид холбоо барихыг зөвшөөрч буй эсэх талаар мэдэгдэнэ үү.</b></p>	<p>Зөвшөөрч байна.</p>



	МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	МЭДЭЭЛЭЛ
1	ТББ-ын нэр /Монгол, Англи хэл дээр/	<b>Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг</b> (МНЭММН) Mongolian Public Health Professionals' Association (MPHPA)
2	Холбогдох мэдээлэл /хаяг, цахим шуудан, утас, вэб хуудас, нэмэлт мэдээллийн холбоос, холбоо барих гол ажилтны мэдээлэл, хэрэв орон нутгийн салбартай бол хаяг/	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, 3-р байр, 46 тоот Шуудангийн салбар 46А, ШХ-229 Утас/Факс: 976-11-325190 Э-шуудан: mphpa.mongolia@gmail.com Вебсайт: <a href="http://www.mphpa.com">http://www.mphpa.com</a> Холбоо барих гол ажилтан: Б.Энхтуяа Албан тушаал: Гүйцэтгэх захирал Facebook хаяг: МРНРА
3	Байгууллагын үүсгэн байгуулагдсан товч түүх	МНЭММН нь 2001 онд үүсгэн байгуулагдаж, 2003 оноос идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсэн.  Соросын сангийн дэмжлэгтэйгээр нийгэмлэгийн анхны гишүүд сар бүр уулзаж нийгмийн эрүүл мэндийн хөгжлийн талаар ярилцдаг байсан ба тус уулзалтуудаас анхны санаа гарч нийгэмлэг үүсгэн байгуулагдсан.
4	Байгууллагын тухай товч хураангуй	Нийгэмлэг нь бодлогын нөлөөлөл, судалгаа, сургалт, төсөл хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.  Гишүүнчлэлтэй байгууллага бөгөөд нийт 100 орчим идэвхтэй болон дэмжигч гишүүдтэй. Эдгээр гишүүдийн 50-иас дээш хувь нь гадны оронд магистр, докторын зэрэг хамгаалсан, туршлагатай гишүүд байдаг. Иймээс аливаа томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өөрсдийн нөөц бололцоон дээрээ тулгуурлан хэрэгжүүлдэг.  Нийгэмлэг нь 2010 оноос хойш Дэлхийн нийгмийн эрүүл мэндийн нийгэмлэгүүдийн холбооны гишүүнээр ажиллаж байна.
5	Эрхэм зорилго	Хүн амын эрүүл мэндийг хамгаалахад мэргэжилтний чадавхыг нэгтгэн дайчилж, олон талт хамтын ажиллагааг сайжруулах замаар Монгол улсад нийгмийн эрүүл мэндийн тогтвортой хөгжлийг дэмжих
6	Гол зорилтот бүлэг	Эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнүүд (эмч, сувилагч, нийгмийн ажилтнууд, статистикч гэх мэт) Төрийн байгууллагууд (хороодын ажилтнууд-засаг дарга, нийгмийн ажилтнууд, зохион байгуулагч)
7	Хүний нөөц	<b>Байгууллагын дээд удирдлага:</b> Эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал бөгөөд хурлаас удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийг сонгон

		шалгаруулдаг. Удирдах зөвлөлийн 7 гишүүн, хяналтын зөвлөлийн 3 гишүүнтэй.
		<b>Гол гишүүд, мэргэжилтнүүд:</b> Одоогоор гүйцэтгэх захирал, хөтөлбөрийн ажилтан, захиргаа, санхүүгийн ажилтан, Австралийн сайн дурын ажилтан гэсэн 4 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр өдөр тутмын үйл ажиллагааг хөтлөн явуулж байна.
8	<b>Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулсан орон нутаг /аймаг, дүүрэг/, орон нутгийн салбарын сүлжээ</b>	1) <b>Сургалт</b> -Аймгуудын Эрүүл мэндийн газрууд (Өмнөговь, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар, Увс, Орхон, Ховд, Баян-Өлгий гэх мэт) 2) <b>Судалгаа</b> - “Дорноговь аймгийн хүн амын эрүүл мэндийн байдалд хийсэн баримт бичгийн судалгаа”. 3) <b>Эрүүл аюулгүй байдлын индекс</b> – Улаанбаатар хотын 9 дүүрэг, түүний 152 хороо, Говьсүмбэр аймаг
9	<b>Өнгөрсөн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл</b>	- Нотолгоонд суурилсан бодлогын нөлөөлөл - Сургалт - Судалгаа, үнэлгээ - Төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх
10	<b>Нийгмийн эгэх хариуцлага, Ил тод байдал, Сайн засаглалыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 5 хүртэлх тооны санаачилга, төсөл</b>	<b>Төслийн нэр:</b> “Эрүүл, аюулгүй байдлын индексийг сайжруулах” хөтөлбөр <b>Хэрэгжүүлсэн хугацаа:</b> 2014 оноос одоог хүртэл <b>Хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</b> Улаанбаатар хотын 9 дүүрэг, түүний 152 хороо <b>Санхүүжүүлэгч:</b> Нийслэлийн Засаг даргын тамгын газар <b>Хамтран ажилласан байгууллагууд:</b> Улаанбаатар хотын Засаг даргын тамгын газар, 9 дүүргийн Засаг даргын тамгын газар, түүний 152 хороо <b>Гол үйл ажиллагаа:</b> Улаанбаатар хотын 9 дүүргийн 152 хорооны эрүүл, аюулгүй байдлын индексийн матрицийг боловсруулан тайлан, зөвлөмж гаргах, ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах зэрэг зөвлөх үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. <b>Гол хүрсэн үр дүн:</b> Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дүүрэг, хороо бүрийн эрүүл, аюулгүй байдлын индексийг тодорхойлж, тулгамдаж буй асуудал болон сул байгаа үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулж, үр дүнтэй хариу арга хэмжээ авч ажиллахаас гадна төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой зөв хуваарилахад ач холбогдолтой хөтөлбөр төдийгүй “Хотжилт ба эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр батлагдах эх үндэс болсон. <b>Төслийн нэр:</b> “Залцбургийн олон улсын эмч нарын семинар” тэтгэлэгт хөтөлбөр <b>Хэрэгжүүлсэн хугацаа:</b> 2003 оноос одоог хүртэл <b>Хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</b> 21 аймаг <b>Санхүүжүүлэгч:</b> Америк Австрийн сан

	<p><b>Хамтран ажилласан байгууллагууд:</b> ЭМСЯ, 3-р шатлалын эмнэлгүүд, 21 аймгийн Эрүүл мэндийн газар, түүний харьяа эмнэлгүүд, Нийслэлийн эрүүл мэндийн газар, түүний харьяа эмнэлгүүд, хувийн эмнэлгүүд, мэргэжлийн нийгэмлэгүүд</p> <p><b>Гол үйл ажиллагаа:</b> Хөтөлбөрийн сурталчилгаа, өргөдөл гаргасан эмч нарын материал бүрдэлтийг хянах, зөвлөгөө өгөх, англи хэлний шалгалт, семинарт сонгогдсон эмч нарын виз, нислэг гэх мэт бүхий л асуудлыг зохицуулан ажиллаж байна.</p> <p><b>Гол хүрсэн үр дүн:</b> 2015 оны 12 сарын байдлаар 427 эмч Залцбург хотод 7 хоногийн семинарт хамрагдаж, 47 эмч Австри улсад 21 хоногийн клиникийн дадлага хийснээс гадна эх орондоо 2 удаа профессоруудыг урьж авчран сургалт хийсэн.</p> <hr/> <p><b>Төслийн нэр:</b> “Халдварт бус өвчин, Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” эрүүл мэндийн төсөл</p> <p><b>Хэрэгжүүлсэн хугацаа:</b> 2009-2013 он</p> <p><b>Хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</b> үндэсний хэмжээнд</p> <p><b>Санхүүжүүлэгч:</b> Монголын Мянганы сорилтын сан,</p> <p><b>Хамтран ажилласан байгууллагууд:</b> ЭМСЯ, ХЗЯ, ЗТЯ, ХХААЯ, ЦЕГ, ЗЦГ, МҮОНРТ, НБГ, НЭМГ, 21 аймаг, Үндэсний Үйлдвэрлэгч гэх мэт</p> <p><b>Гол үйл ажиллагаа:</b> “Эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөн”, “Зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх”, “Архи тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх” кампанит ажлын хүрээнд бүхий л ухуулга нөлөөллийн ажлыг мэргэжлийн байгууллага болон шийдвэр гаргагч нарын төвшинд хийсэн.</p> <p><b>Гол хүрсэн үр дүн:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- “Эрүүл хоол, идэвхтэй хөдөлгөөн” кампанит ажлын хүрээнд “Атар өргөө” компани талхныхаа давсны хэмжээг 10% хувиар, “Талх чихэр” компани 9 төрлийн талхны давсны хэмжээг 12% бууруулж, Монсүү компани 5 төрлийн бүтээгдэхүүнд агуулагдах сахарын хэмжээг 3-5%, тослогийг 2-2.5% бууруулж, шинээр 3 төрлийн сахаргүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн;</li> <li>- “Архи тамхины хор хөнөөлөөс сэргийлэх” кампанит ажлын хүрээнд шийдвэр гаргагч нарт зориулсан баримтын хуудас боловсруулж, хуулийн хэлэлцүүлгийг хэд хэдэн удаа хийснээр Тамхины шинэчилсэн хуулийг өөрчлөхөд хувь нэмрээ оруулсан;</li> <li>- “Зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх” кампанит ажлын хүрээнд Орхон аймаг 6 сая төгрөгийн санхүүжилт гаргаж аймагтаа аян зарлаж ажилласан бол “Монгол даатгал” компани 12 сургуулийн 2200 сурагчдад “Цацруулагчтай цүнхний уут” төслийг хэрэгжүүлсэн.</li> </ul> <hr/> <p><b>Төслийн нэр:</b> “Эрүүл мэнд, эдийн засагт учруулах архины дарамтыг судлах нь” судалгаа</p> <p><b>Хэрэгжүүлсэн хугацаа:</b> 2015 оны 7-12 сар</p> <p><b>Хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</b> сонгогдсон 4 аймаг, 4 сум, 2 дүүрэг</p> <p><b>Санхүүжүүлэгч:</b> Хууль зүйн яамны “Архидан согтуурахтай тэмцэх сан</p>
--	---



	<p><b>Хамтран ажилласан байгууллагууд:</b> Хууль зүйн яам, сонгогдсон аймаг дүүргүүдийн ЗДТГ, Хууль зүйн хэлтэс, Эрүүл мэндийн газрууд, Төрийн бус байгууллагууд</p> <p><b>Гол үйл ажиллагаа:</b> Архины хэрэглээний өнөөгийн байдалд дүгнэлт хийх, эрүүл мэнд, эдийн засагт учруулж буй дарамтыг шууд ба шууд бус зардлаар тооцоолох, анхан шатанд архидан согтуурахын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, цаашид архины хор үршигтай үр дагавар, нөлөөг бууруулахад анхаарах зүйлсийн талаар зөвлөмж боловсруулах</p> <p><b>Гол хүрсэн үр дүн:</b> “Эрүүл мэнд, эдийн засагт учруулах архины дарамтыг судлах” судалгааны ажлын тайланг зөвлөмжийн хамт боловсруулан санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлснээс гадна тус судалгааны тайланг энэ чиглэлээр ажилладаг байгууллагуудад нээлттэй ашиглуулах үүднээс өөрийнхөө вебсайтад байршуулсан. Судалгааг Монголд анх удаа хийснээрээ онцлог төдийгүй ДЭМБ болон ЭМЯ сайшаалтай хүлээн авсан.</p> <p><b>Жич:</b> Архины хортой хэрэглээг бууруулах нөлөөллийн ажлуудаас гадна тамхины чиглэлээр дорвитой ажлуудыг хийж байсан туршлагатай. Бид 2003, 2009 оны тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажил, 2006 онд “Монгол улсын үндэсний бодлогыг тамхины хяналтын суурь конвенцитай хурьцуулсан судалгаа, 2007 онд тамхины хайрцган дээрх зурагт анхааруулга, 2012 оны Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлуулахад хувь нэмрээ оруулж байсан туршлагатай.</p> <p><b>Төслийн нэр:</b> “Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” туршилтын загвар төсөл</p> <p><b>Хэрэгжүүлсэн хугацаа:</b> 2012-2013 он</p> <p><b>Хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</b> Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээ үзүүлж буй Энэрэл эмнэлэг</p> <p><b>Санхүүжүүлэгч:</b> Азийн хөгжлийн банк (АХБ)</p> <p><b>Хамтран ажилласан байгууллагууд:</b> АХБ, Энэрэл эмнэлэг</p> <p><b>Гол үйл ажиллагаа:</b> Тусламж үйлчилгээний өнөөгийн байдлыг үнэлэн тайлан гаргаж, стратеги төлөвлөгөө боловсруулсан.</p> <p><b>Гол хүрсэн үр дүн:</b> Үнэлгээний үр дүнг баримтын цомог хэлбэрээр хэвлэн нийтийн хүртээл болгосноос гадна стратеги төлөвлөгөөг боловсруулан Энэрэл эмнэлэг болон АХБ-нд хүлээлгэн өгсөн.</p>
--	--

11	<p><b>Тус байгууллага нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд ямар давуу талууд үзүүлэн орон нутгийн оролцогч талуудад хэрхэн чадварлаг зөвлөгч/түншлэгч байж чадах талаар тайлбарлана уу. (жишээлбэл: арга хэрэгсэл, механизм ашигласан туршлага, зорилтот бүлэгт гарсан үр нөлөө, 5 хүртэлх өгүүлбэрт бичих)</b></p>	<p>Манай байгууллага нь дараах чиглэлүүдээр орон нутгийн байгууллагуудтай хамтрах/зөвлөх байдлаар ажиллах боломжтой.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн эгэх хариуцлагыг сайжруулах ажлын хүрээнд иргэд, олон нийт, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас гарсан саналын дагуу төсөл боловсруулан, санаачлан хэрэгжүүлэх</li> <li>- Одоогийн төрийн үйлчилгээнд байгаа үйл ажиллагаанд үнэлгээ, судалгаа хийх, мөн цаашид сайжруулах чиглэлээр зөвлөмж гаргахаас гадна туршилтын төслийг хамтран хэрэгжүүлэх</li> <li>- Төрийн байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах чиглэлээр хэрэгцээнд суурилсан төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулах</li> </ul> <p>Нийгэмлэг нь байгуулагдсан цагаасаа эхлэн олон төрлийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн туршлагатай.</p> <p>Төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн тулгамдсан асуудлуудад (гарсан саналын дагуу) тулгуурлан гол хэрэгжүүлэгч байгууллагууд, төрийн бус байгууллага, зорилтот бүлэг болох олон нийттэй уулзаж ярилцан, тохиолцсоны үр дүнд оновчтой, үр дүн өгөхүйц, тогтвортой байдлыг хангасан төслийг боловсруулан хэрэгжүүлнэ. Төслийг боловсруулахад нийгэмлэг ахлан боловсруулах ба төсөл хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үүрэг хариуцлагыг маш тодорхой ойлгомжтой тусгаж, хамтран хэрэгжүүлнэ. Хэрэгжүүлэх явцад гарсан бэрхшээлийг цаг алдалгүй шийдвэрлэх, хяналтыг бүхий л оролцогч талуудын төвшинд хийсний үр дүнд хэрэгжилтийг сайжруулна.</p> <p>Үүний хажуугаар орон нутгийн Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийг чадавхжуулахад анхаарлыг хандуулна. Ингэснээрээ орон нутаг эмнэлэгт суурилсан үйлчилгээнээс илүүтэй урьдчилан сэргийлэх чиглэл рүү ажиллана.</p> <p>Мөн орон нутгийн байгууллагуудын ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор тухайн асуудал, хэрэгцээнд нийцсэн сургалтыг зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтарна.</p>
12	<p><b>Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож/төлөвлөж буй аймаг/дүүрэг /хэрэв байгаа бол/</b></p>	<p>Одоогоор сонгосон аймаг байхгүй ч Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар “Хотжилт-Эрүүл мэнд” үндэсний хөтөлбөртэй холбогдуулан эхний удаагийн сургалт авахаар хүсэлтээ аман байдлаар илэрхийлсэн.</p> <p>Бид өмнөх туршлагүүддаа үндэслэн аль ч аймаг/дүүрэгтэй хамтран ажиллахдаа бэлэн байна.</p>
13	<p><b>Тус байгууллагын талаарх дээр дурьдагдаагүй нэмэлт</b></p>	<p>Нийгэмлэг нь гишүүддээ зориулсан туршилтын Менторын хөтөлбөр"-ийг 2015 оноос хэрэгжүүлж эхлэсэн.</p> <p>Тус хөтөлбөрийн зорилго нь нийгэмлэгийн туршлагатай, чадвартай, олонд танигдсан гишүүдээс ментороор сонгон, шинэ</p>

	<b>мэдээлэл /3 хүртэлх өгүүлбэр/</b>	залуу гишүүдийг (менти) чадваржуулах юм. Хэдийгээр тус хөтөлбөрт 8 гишүүн хамрагдсан ч 4 менти нь өөрийн төлөвлөсөн зорилтондоо хүрч амжилттай ажилласан. Үүний үр дүнд тус хөтөлбөрийн дараагийн элсэлтийг авч эхэлж байна.
14	<b>МУНЭХБ төслийн хүрээнд тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, цаашид холбоо барихыг зөвшөөрч буй эсэх талаар мэдэгдэнэ үү.</b>	Мэдээллийг хуваалцахыг хүлээн зөвшөөрч байгаа ба цаашид орон нутагтай үйл ажиллагаагаа өргөжүүлэн хамтран ажиллахдаа таатай байх болно.

	МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	МЭДЭЭЛЭЛ
1	ТББ-ын нэр /Монгол, Англи хэл дээр/	<b>Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ</b>
2	Холбогдох барих мэдээлэл /хаяг, цахим шуудан, утас, вэб хуудас, нэмэлт мэдээллийн холбоос, холбоо барих гол ажилтны мэдээлэл, хэрэв орон нутгийн салбартай бол хаяг/	Сүлжээний зохицуулагч П.Цэвээн-99010297 <b>Монголын Хүүхдийн ордон 02 тоот Утас -328926</b> <a href="mailto:tzeveen@yahoo.com">tzeveen@yahoo.com</a>  Хүүхдийн эрхийн сургалт судалгааны хүрээлэнгийн тэргүүн Б. Жавзанхүү . 99103678 <a href="mailto:Javzanhuu@yahoo.com">Javzanhuu@yahoo.com</a>
3	Байгууллагын үүсгэн байгуулагдсан товч түүх	2007 онд төрийн бус 10 байгууллага хамтран сүлжээний хэлбэрээр нэгдэж ажиллахаар зохион байгуулагдсан . 2008 онд хуулийн этгээдээр бүртгүүлсэн.
4	Байгууллагын тухай товч хураангуй	Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ нь байгуулагдсан цагаасаа эхлэн хамгаалал шаардсан эрсдэлд өртсөн яаралтай тусламж үйлчилгээ шаардсан хүүхдүүдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр мэргэшсэн 17 байгууллага нэгдэж ажилладагаас гадна,нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхдийн эрх ноцтой зөрчигдөж байгаа асуудалд үндэсний хэмжээнд анхаарал хандуулах үүднээс стертагийн өмгөөлөл хийх,хяналт мониторингийн чиглэлээр үнэлгээ дүгнэлт гаргах,хүүхдийн байдалд судалгаа хийх зэрэг олон ажлуудыг хийж ирсэнээс гадна 2016 онд хүүхдийн эрх,хамгаалалын 2 хууль гаргаж батлуулахад тодорхой хувь нэмэр оруулж ажилласнаас гадна,бодлого,хөтөлбөр боловсруулхад онцгой байр суурь эзэлж оролцож байдаг нь нийгэмд танигдсан байр сууриа зөв эзэлсэн сүлжээ гэж баттай хэлж чадах боломж нөхцөл бүрдсэн.
5	Эрхэм зорилго	Хүүхэд хамгааллын тогтолцоог орон нутаг, үндэсний хэмжээнд хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах
6	Гол зорилтот бүлэг	Эрсдэлд нөхцөлд байгаа хүүхэд тэдний хамгаалагдах эрх, эрх нь зөрчигдсөн хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх
7	Хүний нөөц	<b>Байгууллагын дээд удирдлага:</b> Сүлжээний удирдах зөвлөл <b>Гол гишүүд, мэргэжилтнүүд:</b> Зохицуулагч байгууллагаа 2-3 жилийн хугацаагаар ээлжлэн сонгогдож ажилладаг.
8	Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулсан орон нутаг /аймаг, дүүрэг/, орон нутгийн салбарын сүлжээ	Сүлжээнд нэгдсэн 17 байгууллага нь сургалт сурталчилгаа нөлөөлөлийн үйл ажиллагаагаараа үндэсний хэмжээнд ажилладаг багөөд,судалгаа,мониторингийн ажлыг сонгосон аймаг орон нутагт,төвийн,хангайн,баруун,зүүн бүсээс сонгож хийдэг бөгөөд

		хүүхдийн асуудал дээр аймаг суманд очиж мэргэжлийн үйлчилгээ үзүүлсээр ирсэн_
9	<b>Өнгөрсөн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Бэлгийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх</li> <li>- Хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх үйлчилгээ</li> <li>- Эмзэг бүлгийн өрх, гэр бүл, нийгмийн орчинд хүүхдийн хамгаалагдах эрхийн хэрэгжилттэй холбоотой чанарын судалгаанууд</li> <li>- Нийгмийн ажилтны мэргэжлийн үүрэг, манлайлал, оролцоо зөвлөлдөх бага хурал, уулзалт</li> <li>- Хүүхэд хамгааллын процессын хууль тогтоомжийн төслийг сайжруулах уулзалт, семинар, иргэд, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх “Ногоон карт” аян</li> <li>-</li> </ul>
10	<b>Нийгмийн эрх хариуцлага, Ил тод байдал, Сайн засаглалыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 5 хүртэлх тооны санаачилга, төсөл</b>	<p><b>Төслийн нэр, хэрэгжүүлсэн хугацаа, хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээг шинэчлэх төсөл үндэсний хэмжээнд төсөлд хамрагч талуудын хамт 2014 он</li> <li>2. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, 2013-2014 он</li> <li>3. Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглалын судалгаа 2015 он</li> <li>4. Хүүхэд хамгаалалд иргэдийн оролцоо төслийн хүрээнд хүүхдийн эрх, хамгааллын талаарх хуулийн төслийн иргэдийн хэлэлцүүлэг, 2015 он</li> </ol> <p><b>Хамтарч ажилласан байгууллага, хандивлагч байгууллага:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. ДЗМОУБ, Мобиком, ХТҮГ</li> <li>2. ХТҮГ, НҮБХС, үндэсний зөвлөүүд</li> <li>3. ДЗМОУБ, үндэсний зөвлөүүд, ХТҮГ</li> <li>4. УИХ ын НББСШУБХ, ДЗМОУБ, ХТҮГ</li> </ol> <p><b>Гол үйл ажиллагаа, хүрсэн үр дүн тус бүрийн талаар товч нэг өгүүлбэр</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Утсыг 24 цагаар, үнэ төлбөргүй, мэргэжлийн зөвлөгч сонсож мэдээллийг бүртгэх, зөвлөх, хариу үйлчилгээнд холбон зуучилж, хянах хэлбэрийг шийдэж програмчилж ажилласан.</li> <li>2. Бодлогын баримт бичгийг Хүүхдийн Төлөө үндэсний газрын даргын 2014 оны 11-р сарын 20-ны өдрийн тушаалаар баталсан</li> <li>3. Үндэсний хэмжээнд тайлан гарсан.</li> <li>4. Ногоон картны аянд 22,000 хүний санал хүлээж авч УИХ – аар батлагдсан.</li> </ol>

11	<p><b>Тус байгууллага нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд ямар давуу талууд үзүүлэн орон нутгийн оролцогч талуудад хэрхэн чадварлаг зөвлөгч/түншлэгч байж чадах талаар тайлбарлана уу. (жишээлбэл: арга хэрэгсэл, механизм ашигласан туршлага, зорилтот бүлэгт гарсан үр нөлөө, 5 хүртэлх өгүүлбэрт бичих)</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Эмзэг бүлгийн өрхийн иргэд, өсвөр үеийхэнтэй ажиллах ажлын арга туршлагатай</li> <li>- Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн.</li> <li>- Сургалт сурталчилгаа нөлөөлөлийн ажил</li> <li>- Тодорхой хүүхдийн асуудлыг боловсоруулах асуудал дээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг</li> <li>- Хүүхэд харах үйлчилгээний сургагч багшаар бэлтгэгдсэн</li> <li>- Хүүхдийн эрхийн болон,хүүхэд хамгаалалын хууль хэрэгжүүлэхэдтэй бологдон гарах 16 дүрэм, журам,стератег дээр зөвлөхөөр ажиллаж байна.</li> <li>- 2016-2025 он хүртэл хэрэгжих хүүхдийн хөгжил хамгаалалын үндэсний хөтөлбөр боловсоруулах ажлыг зарим байгууллага гэрээлэн гүйцэтгэх ажил хийэ байна.</li> </ul>
12	<p><b>Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож/төлөвлөж буй аймаг/дүүрэг /хэрэв байгаа бол/</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- СХД ийн Баянхошуу орчимд</li> <li>- БЗД ийн Нарантуул, Өгөөмөр зах орчимд</li> <li>- Ховд, Өвөрхангай, Орхон, Төв, Дорнод аймагт хүүхдийн элчийг дэмжих чиглэлд хүүхдийн эрх, хамгааллыг дэмжих орчин бүрдүүлэх нөхцөлийг дэмжин төрийн байгууллага, иргэн, гэр бүл, хуулийн этгээдтэй хамтран ажиллах зорилготой .</li> </ul>
13	<p><b>Тус байгууллагын талаарх дээр дурьдагдаагүй нэмэлт мэдээлэл /3 хүртэлх өгүүлбэр/</b></p>	<p><b>Үндэсний сүлжээний гишүүн ТБ байгууллагууд:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хүүхдийн эрхийн үндэсний төв ТББ</li> <li>2. Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэн ТББ</li> <li>3. Хүүхдийн эрх, хамгаалал төв ТББ</li> <li>4. Монгол өрх сэтгэл зүйн төв ТББ</li> <li>5. Гүнж төв ТББ</li> <li>6. Хөөрхөн зүрхний аян ТББ</li> <li>7. Цөлийн сарнай төв</li> <li>8. Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг ТББ</li> <li>9. Эрч хүчтэй хүүхдүүд ТББ</li> <li>10. Хөгжлийн хэлхээ ТББ</li> <li>11. Эвт сайн хөрш ТББ</li> <li>12. Том ах эгч ТББ зэрэг 15 байгууллага байна.</li> </ol>
14	<p><b>МУНЭХБ төслийн хүрээнд тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, цаашид холбоо барихыг зөвшөөрч буй эсэх талаар мэдэгдэнэ үү.</b></p>	<p>Бүрэн боломжтой.</p>



	МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	МЭДЭЭЛЭЛ
1	ТББ-ын нэр /Монгол, Англи хэл дээр/	“Ил тод байдал сан” ТББ Transparency Foundation NGO
2	Холбогдох барих мэдээлэл /хаяг, цахим шуудан, утас, вэб хуудас, нэмэлт мэдээллийн холбоос, холбоо барих гол ажилтны мэдээлэл, хэрэв орон нутгийн салбартай бол хаяг/	Гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав Утас: 99163657, И-мэйл: <a href="mailto:tseren2005@yahoo.com">tseren2005@yahoo.com</a> Ажилтан Б.Бямбасүрэн Утас: 88100882, И-мэйл: <a href="mailto:budvaabyambaa@yahoo.com">budvaabyambaa@yahoo.com</a> Цахим сайт: <a href="http://www.iltod.mn">www.iltod.mn</a> , <a href="http://www.ilzasag.mn">www.ilzasag.mn</a>
3	Байгууллагын үүсгэн байгуулагдсан товч түүх	2006 онд үүсгэн байгуулах хурлаа хийж 2007 онд Улсын бүртгэлийн гэрчилгээгээ авснаар үйл ажиллагаа явуулж эхэлсэн
4	Байгууллагын тухай товч хураангуй	“Ил тод байдал сан” ТББ нь төрийн болон орон нутгийн төр захиргааны байгууллагууд, бас уул уурхай, хэвлэл мэдээлэл зэрэг зарим онцлох салбарын мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт тавьж мониторинг судалгаа хийж дүгнэлт, санал зөвлөмж боловсруулан ажилладаг, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм
5	Эрхэм зорилго	“Ил тод нээлттэй төрийн төлөө”
6	Гол зорилтот бүлэг	- Төрийн захиргааны болон орон нутгийн төр, захиргааны байгууллагын удирдах ажилтан, албан тушаалтнууд - Иргэний нийгмийн байгууллагууд - Идэвхтэй иргэд
7	Хүний нөөц	<b>Байгууллагын дээд удирдлага:</b> Удирдах зөвлөл (5 хүнтэй): 1. Д.Батмөнх, хуульч, өмгөөлөгч (Удирдах зөвлөлийн дарга) 2. З.Алтанхуяг, МҮХАҮТ-ын ажилтан 3. З.Батболд, Эдийн засагч 4. Б.Болд, “Бизнес таймс” сонины эрхлэгч 5. Б.Байгальмаа, эдийн засагч <b>Гол гишүүд, мэргэжилтнүүд:</b> Д.Цэрэнжав Б.Бямбасүрэн Ц.Отгонсүрэн
8	Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулсан орон нутаг /аймаг, дүүрэг/, орон нутгийн салбарын сүлжээ	Нэг. Гол төлөв нийслэл Улаанбаатар хот, түүний дүүргүүдэд үйл ажиллагаа явуулдаг. Ялангуяа сүүлийн жилүүдэд Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар дүүрэгт тусгайлан ажиллаж байсан. Хоёр.



		<p>Орон нутагт салбаргүй. Гэхдээ орон нутагт чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн сүлжээний идэвхтэй гишүүн байгууллага юм. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Иргэд төсвөө хянаана” сүлжээ</li> <li>- “Төлсөн авснаа нийтэл” эвсэл</li> <li>- “Ил тод байдлыг дэмжих түншлэл”</li> </ul>
9	<p><b>Өнгөрсөн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл</b></p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Төрийн захиргааны төв байгууллага (яам, агентлаг)-ын мэдээллийн ил тод, нээлттэй байдалд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу хяналт тавьж ирсэн</li> <li>2. Орон нутгийн төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдалд тасралтгүй мониторинг хийж ажилладаг</li> <li>3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын үйл явцад ТАН эвслийн үүсгэн байгуулагч гишүүний хувьд идэвхтэй оролцож ирсэн.</li> <li>4. Байгаль орчны мэдээллийн ил тод байдал, байгаль орчны мэдээллийн санг орон нутгийн иргэдэд нээлттэй, хүртээмжтэй болгох асуудлаар үргэлжлүүлэн ажиллаж байна.</li> </ol>
10	<p><b>Нийгмийн эгэх хариуцлага, Ил тод байдал, Сайн засаглалыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 5 хүртэлх тооны санаачилга, төсөл</b></p>	<p><b>Төслийн нэр, хэрэгжүүлсэн хугацаа, хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</b></p> <p>Нэг.</p> <p>2013-2015 онуудад Засгийн газрын яам, агентлагууд өөрсдийн үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөц, удирдлагын томилгоо, дотоод худалдан авалт гэх мэт анхаарал татсан чухал мэдээллийн ил тод байдлыг хэрхэн хангаж байгаад өргөн хүрээтэй мониторинг явуулж үнэлгээ хийсэн.</p> <p>Хоёр.</p> <p>2013 оноос хойш нийслэл ба түүний дүүргүүдийн төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдаан болон баримт бичгийн ил тод нээлттэй байдалд жил тутам, оны эцэст болон дараа оны эхээр мониторинг хийн ажиллаж ирсэн.</p> <p>Гурав.</p> <p>Мөн 2011, 2014 онуудад Олон улсын төсвийн түншлэл байгууллагын арга зүйн дагуу “Орон нутгийн төсвийн ил тод байдлын индекс” судалгаанд иргэний нийгмийн байгууллагуудыг зохион байгуулж оролцсон. Одоо 2016 оны ээлжит судалгаанд мөн дээрх байдлаар оролцохоор бэлтгэж байна.</p> <p>Дөрөв.</p> <p>2015 оны эхний хагас жилд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг нийслэл Улаанбаатар хотын жишээн дээр судалж дүгнэлт гаргасан Тав.</p> <p>2014 оноос эхлэн “Байгаль орчны мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь” төслийг Туул голын сав газар, Хан-Уул дүүргийн 13-р хороо, Төв аймгийн Заамар сумын жишээн дээр хэрэгжүүлэхэд баг болон оролцож байна.</p> <p><b>Хамтарч ажилласан байгууллага, хандивлагч байгууллага:</b></p> <p>“Иргэд төсвөө хянаана” иргэний нийгмийн сүлжээ</p> <p>“Ил тод байдлыг дэмжих түншлэл” ТББ</p> <p>ТАН эвсэл</p>

		<p>Нээлттэй нийгэм форум Азийн сан</p> <p><b>Гол үйл ажиллагаа, хүрсэн үр дүн тус бүрийн талаар товч нэг өгүүлбэр</b> <b>Төслийн нэр, хэрэгжүүлсэн хугацаа, хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</b> Нэг. Төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийн “Ил тод, нээлттэй байдлын карт”-ын загварын боловсруулж гаргасан ба 17 яам, 29 агентлагийн жишээн дээр 2015 оны байдлаар бүрдүүлсэн ба үүнд тулгуурлан яам, агентлагын ил тод, нээлттэй байдлын индекс (рейтинг)-ийг хэд хэдэн удаа гарган зарлаж байсан. (Энэ талаар <a href="http://www.ilzasag.mn">www.ilzasag.mn</a> сайтаас үзэж болно)</p> <p>Хоёр. Нийслэл ба түүний дүүргүүдийн төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны мониторингийн явцад төсвийн үндсэн баримт бичгүүдийг олж аваад холбогдох мэдээллийн хамт <a href="http://www.tusuv.mn">www.tusuv.mn</a> сайтад байршуулан олон нийтийн хяналтанд оруулж яриа хэлэлцүүлэг өрнүүлсэн. Үүнд нийслэл, түүний харьяа 9 дүүргийг хамруулж байгаа болно.</p> <p>Гурав. Орон нутгийн төсвийн ил тод байдлын индекс хэмээх гурван удаагийн судалгааны хүрээнд ИТХ-ын хуралдаанууд тусгай аргачлал, удирдамж боловсруулан түүний дагуу ажиглалт хийн оролцож байгаа нь уг үйл явцад хяналт болохоос гадна иргэний нийгмийн байгууллагууд төсвийн үйл явцыг “ойроос харах”, улмаас чадавхижих боломжийг нээн өгч байна.</p> <p>Дөрөв. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг судалснаар уг хуулийг болон Монгол Улсын шилэн дансны нэгдсэн систем (<a href="http://shilendans.gov.mn">shilendans.gov.mn</a>)-ыг боловсронгуй болгох олон тооны санал зөвлөмж гаргасан</p> <p>Тав. “Байгаль орчны мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь” төслийн үр дүнд байгаль орчны мэдээллийг ил тод, нээлттэй болгох загвар стандарт боловсруулагдан дуусч байна. Энэ нь орон зайн зураглалд суурилж байгаагаараа шинэлэг юм.</p>
11	<p><b>Тус байгууллага нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд ямар давуу талууд үзүүлэн орон нутгийн оролцогч талуудад хэрхэн чадварлаг зөвлөгч/түншлэгч байж чадах талаар тайлбарлана уу.</b></p>	<p>1. Манай байгууллага төрийн байгууллагын мэдээллийг ил тод, нээлттэй байдлыг судлах, үнэлж дүгнэх, зааж сургахаар хязгаарладаггүй бөгөөд бодитойгоор ил тод болгож ажилладаг онцлогтой. Өөрөөр хэлбэл сонгож сэдэв, асуудал, байгууллагын талаар иргэд олон нийт мэдэх ёстой гэж үзсэн мэдээллийг янз бүрийн эх сурвалжаас цуглуулах, ажиглалт хийх, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу хүсэлт тавих, мөн эрэн сурвалжлах зэрэг олон аргаар олж аваад өргөн олон нийтэд нээлттэй болгодог.</p> <p>2. Нэгэнт нээлттэй болсон их хэмжээний мэдээллийг байршуулах, орон зай, цаг хугацаанаас үл хамааран түгээж хүргэх, хадгалах хамгийн үр дүнтэй суваг болсон цахим сайтыг хийж ажиллуулах</p>

	<p><b>(жишээлбэл: арга хэрэгсэл, механизм ашигласан туршлага, зорилтот бүлэгт гарсан үр нөлөө, 5 хүртэлх өгүүлбэрт бичих)</b></p>	<p>талаар сүүлийн жилүүдэд нэлээд туршлага хуримтлуулсан. Ингэхдээ иргэний нийгмийн байгууллагын боломж, чадавхид тохирсон энгийн сайтуудыг өргөн ашигладаг. Зарим жишээ дурдвал</p> <ul style="list-style-type: none"> <li>- llzasag.mn</li> <li>- llniislel.mn</li> <li>- baigaliorchin.mn</li> <li>- baigalorchin.wordpress.com</li> <li>- llmongol.mn</li> <li>- tusuv.mn (Дотроо 5 дэд сайтаас бүрддэг)</li> </ul> <p>Мөн манай байгууллагын өөрийн iltod.mn хэмээх танилцуулга сайт, бас эрэн сурвалжлагын мэдээлэл солилцох хаалттай сайт бий.</p> <p>3.Төрийн захиргааны байгууллагууд, төрийн өндөр албан тушаалтнуудад талаархи янз бүрийн сэдэв, түвшин, цаг хугацааны мэдээллийг хадгалах иргэний нийгмийн ой санамж (төрийн ой санамжийн жишгээр)-ыг бүрдүүлэхэд чиглэсэн мэдээллийн сангийн загварыг боловсруулан өөрсдөө ашиглаж байна. Бид өнгөрсөн хугацаанд төрийн байгууллагын холбогдолтой хамгийн их мэдээллийг цуглуулан хадгалж буй иргэний нийгмийн байгууллага гэж өөрсдийгөө тооцдог.</p>
12	<p><b>Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож/төлөвлөж буй аймаг/дүүрэг /хэрэв байгаа бол/</b></p>	<p>Бид цаашид төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах, төрийн болон хувь хүний нүүцаас бусад өгөгдөл, баримт бичиг, мэдээ, тайлан, танилцуулга зэргийг ил тод болгох үр дүнтэй арга загварыг боловсруулах, big data-гийн зарчмаар анализ, дүн шинжилгээ хийх, мөн иргэний нийгмийн байгууллагууд ашиглаж болохуйц цахим мэдээллийн арга зүй, аргачлалыг боловсруулах чиглэээр ажиллах сонирхолтой байгаа болно.</p>
13	<p><b>Тус байгууллагын талаарх дээр дурьдагдаагүй нэмэлт мэдээлэл /3 хүртэлх өгүүлбэр/</b></p>	<p>Манай байгууллага төсвийн чиглэлээрхи үйл ажиллагааныхаа хүрээнд нийгмийн даатгалын сангийн удирдлага, зохион байгуулалт, уг сангийн хөрөнгийн зарцуулалтын талаар мэдээлэл цуглуулж ирсэн ба энэ жилээс Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэн, өмнө нь Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлд багтдаг байсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь тусдаа бие даасан бүтэцтэй байхаар болсны дагуу хяналт мониторинг хийж ажиллахад бэлэн байна.</p>
14	<p><b>МУНЭХБ төслийн хүрээнд тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, цаашид холбоо барихыг зөвшөөрч буй эсэх талаар мэдэгдэнэ үү.</b></p>	<p>Бид хамтран ажиллах бүх талын оролцогчдод бид нээлттэй байх болно.</p>

	МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	МЭДЭЭЛЭЛ
1	ТББ-ын нэр /Монгол, Англи хэл дээр/	<b>Хүний хөгжил, Нөхөн үржихүйн эрүүл мэнд/Эрх ТББ-уудын сүлжээ</b> Human Development RHR NGO's network
2	Холбогдох барих мэдээлэл /хаяг, цахим шуудан, утас, вэб хуудас, нэмэлт мэдээллийн холбоос, холбоо барих гол ажилтны мэдээлэл, хэрэв орон нутгийн салбартай бол хаяг/	Б.Алтанчимэг-Ерөнхий зохицуулагч Email: <a href="mailto:ag232616@yahoo.com">ag232616@yahoo.com</a> FB: Hd/Rh/r NGOs Network Хүний хөгжил, НҮЭМ, Эрхийн ТББ-уудын сүлжээ FBgroup: RH NGO*s Network (Хүний хөгжил, НҮЭМ/ Эрх ТББ-уудын сүлжээ ) Tel: 976-93090506/976-88784388
3	Байгууллагын үүсгэн байгуулагдсан товч түүх	Монголын 16 томоохон ТББ-ууд Монгол улсад нөхөн үржихүйн эрүүл мэндийн анхны хөтөлбөр хэрэгжиж эхлэх болсонтой холбоотойгоор уг хөтөлбөрийг дэмжиж ажилахаар үүсгэн байгуулагдсан. НҮБХАС сүлжээний үйл ажиллагааг дэмжиж ирсэн.
4	Байгууллагын тухай товч хураангуй	Хүний хөгжил, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх ТББ-уудын сүлжээ. 2001 онд албан ёсоор үүсгэн байгуулагдсан, 8056803 регистрийн дугаар бүхий улсын бүртгэлийн гэрчилгээтэй. Эрүүл мэндийн боловсрол, хүний эрх, жендэр, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүний хөгжлийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг 25 гишүүн байгууллагатай. Нийт хүн ам, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, биеэ үнэлэгч, өсвөр үе залууст нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амд чанартай, хүртээмжтэй нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд үндэсний хэмжээнд дэмжлэг болж, төр иргэнийг холбон ажиллах үндсэн зорилготой сүлжээ байгууллага юм. НҮБХАС-ын санхүүжилтээр нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэн ажиллаж ирсэн. Сүлжээний гишүүн байгууллагууд нь ХДХВ/ДОХ/БЗДХ-ын тухай ойлголт мэдлэгийг үндэсний хэмжээнд түгээхэд Глобал сангийн санхүүжилттэйгээр үндсэн үүрэг гүйцэтгэсэн. Сүлжээний гишүүн байгууллагууд: <ol style="list-style-type: none"> <li>1. Гал Голомт Үндэсний Хөдөлгөөн</li> <li>2. Мари Стопс</li> <li>3. ЛЭОС</li> <li>4. МГБССН</li> <li>5. ДОХ-той Тэмцэх Үндэсний Сан</li> <li>6. Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо</li> <li>7. МУЗН</li> <li>8. Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв</li> </ol>

		<p>9. Хөдөөгийн Эмэгтэйчүүдийн Хөгжлийг Дэмжих Сан</p> <p>10. Өсвөр үе ирээдүй төв</p> <p>11. Монголын Эрэгтэйчүүдийн Холбоо</p> <p>12. Тэргэнцэртэй Иргэдийн Холбоо ТББ</p> <p>13. ЛГБТ төв ТББ</p> <p>14. Гүнж төв</p> <p>15. Залуусын Эрүүл мэнд төв</p> <p>16. Чингэлтэй дүүргийн ХБИРгэдийн холбоо</p> <p>17. Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ</p> <p>18. Хамтдаа төв</p> <p>19. Хар Тамхи Мансууруулах Бодисоос Иргэдийг Хамгаалах Нийгэмлэг</p> <p>20. Хөгжлийн Хэлхээ төв</p> <p>21. Монгол зөн</p> <p>22. Энэрэлийн түүчээ ТББ</p> <p>23. “Сэтгэл зүйн мэдрэмж” ТББ</p> <p>24. Итгэл Шүтээн ТББ</p> <p>25. “АВАМ” Тува эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах ТББ</p>
5	<b>Эрхэм зорилго</b>	<b>Монгол улсан нөхөн үржихүйн эрүүл мэндийн аж байдлыг сайжруулахад сүлжээний хамтын үйл ажиллагаагаар хувь нэмэр оруулах зорилготой.</b>
6	<b>Гол зорилтот бүлэг</b>	Нийт хүн ам, хөдөлдгөөнт хүн ам, ХБИ, Бэлгийн цөөнх, Биеэ үнэлэгч, Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид, Өсвөр насныхан, залуус.
7	<b>Хүний нөөц</b>	<p>Байгууллагын дээд удирдлага: Удирдах зөвлөл-Сүлжээний гишүүн байгууллагуудын 5 удирдлагаас бүрдсэн баг. Сүлжээний 25 гишүүн байгууллагуудын хамтын хүчээр зөвхөн БЗДХ,ХДХВ,ДОХ-оос сэргийлэх чиглэлээр хязгаарлагдахгүйгээр хүний эрх, хүчирхийлэл, засаглал, хяналт үнэлгээний чиглэлээр өргөн хүрээнд багаар ажиллах хүн хүч, техникийн бүрэн чадавхитай.</p> <p>Гишүүн байгууллагын удирдлагууд + 1 байгууллага доод тал нь 3 ажилтантай. 75-120 ажиллах хүч.</p> <p>Гол гишүүд, мэргэжилтнүүд: Сүлжээний ерөнхий зохицуулагч, Сүлжээний нарийн бичиг</p>
8	<b>Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулсан орон нутаг /аймаг, дүүрэг/, орон нутгийн салбарын сүлжээ</b>	<p>НҮЭМ-ийн асуудлаар баруун бүсийн сүлжээ. Үүнд:</p> <p>Улаанбаатар хот</p> <p>Ховд</p> <p>Увс</p> <p>Баян-Өлгий</p> <p>Говь-Алтай</p> <p>Завхан</p> <p>Дорноговь</p> <p>Өвөрхангай</p> <p>Дорнод</p> <p>Өмнөговь</p> <p>Дархан</p> <p>Орхон</p>

		Хөвсгөл
9	<b>Өнгөрсөн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл</b>	БЗДХ,ХДХВ,ДОХ-оос сэргийлэх -Сургалт -Олон нийтийн нөлөөлөл -Бодлогын Нөлөөлөл -Судалгаа -Сүлжээний гишүүн байгууллагуудын чадавхи
10	<b>Нийгмийн эгэх хариуцлага, Ил тод байдал, Сайн засаглалыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 5 хүртэлх тооны санаачилга, төсөл</b>	<p><b>Төслийн нэр, хэрэгжүүлсэн хугацаа, хамарсан аймаг/сум, дүүрэг/хороо:</b> Төслийн нэр, үргэлжилсэн хугацаа: 1)“Эмзэг, алслагдсан дүүргийн хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх нь” төсөл. 5 жил, Баруун 5 аймаг 2) “Ажлын байран дахь бэлгийн дарамтлалыг зогсооё” төсөл. 3 жил. Улаанбаатар, Дорноговь, Өвөрхангай, Дорнод, Өмнөговь, Дархан, Орхон, Хөвсгөл, Ховд 3)“ИНБ-уудын чадавхи бэхжүүлэх” төслийг сүлжээний ажлын албанаас хэрэгжүүлсэн- 6 сар. Мөн БЗДХ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэх мэдлэг ойлголтыг үндэсний хэмжээнд түгээх төслийг сүлжээний гишүүн 12 байгууллага өнгөрсөн 10 жилийн хугацаанд өөр өөрийн зорилтот бүлэгт чиглэн хэрэгжүүлсэн. Гишүүн 25 байгууллага-УБ 4) “Зонхилон тохиолдох халдварт бус 4 төрлийн өвчний эрт илрүүлгийн шинжилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах нь” төсөл. 3 сар. УБ 5) ДОХ-оос сэргийлэх дэлхийн өдөрт зориулсан мэдээллийн аяны төсөл. 3 сар. Үндэсний хэмжээнд Сошиал медиа ашигласан.</p> <p><b>Хамтарч ажилласан байгууллага, хандивлагч байгууллага:</b> Хамтран ажилласан талууд, санхүүжүүлэгч: 1)НҮБХАС 2)МОНЭС 3)Глобаль сангийн ДОХ, сүрьеэгийн төсөл 4)Монголын Мянганы Сорилтын Сан 5) ДЭМБ</p> <p><b>Гол үйл ажиллагаа, хүрсэн үр дүн тус бүрийн талаар товч нэг өгүүлбэр:</b> Гол үйл ажиллагаа, хүрсэн үр дүн /тус бүр нэг өгүүлбэр/: 1) Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, тусламж үйлчилгээг эмзэг, алслагдсан бүс нутгийн хүн амд хүргэх “ДЭМЖИХ БҮЛЭГ”-ийн аргачлалыг бий болгож, орон нутгийн ТББ, төр, олон нийтэд түшиглэсэн байгууллагын төлөөлөл бүхий албан бус бүлгүүдийг үүсгэн байгуулсан. Бүсчилсэн семинаруудыг зохион байгуулж, харилцан туршлага солилцох боломж олгосон, хамтын шийдвэрээр баруун бүсийн 5 бүлэг ээлжээр зохицуулагчаа, сонгон ажилласан. 2) Ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх чиг үүрэг бүхий төр, ТББ, үйлдвэрчний эвлэл, ажил олгогч эздийн холбоо, хувийн хэвшил, иргэдийн оролцоотой нийт 420 сургагч багшыг Улаанбаатар хотын 3 дүүрэг, Дорноговь, Ховд, Өвөрхангай, Дорнод, Өмнөговь,</p>

		<p>Дархан, Орхон, Хөвсгөл, аймгуудад тус тус бэлтгэсэн. АББД-ын асуудлаарх үндсэн ойлголт мэдлэгийг үндэсний хэмжээнд түгээсэн.</p> <p>3) БЗДХ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэх чиглэлээр ажилладаг байгууллагуудын ажилтан нарыг чадавхижуулах, хүрч очих ажилтнуудыг бэлтгэх, ДЭМЖИХ БҮЛГИЙН сургагчаар мэргэшүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн, олон талт оролцооны байгууллагуудын форумыг зохион байгуулж байсан. Монгол улсад БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх үндсэн ойлголт мэдлэгийг түгээхэд сүлжээний гүшүүн байгууллагуудын хамтын хүчээр гол цөм үүргийг гүйцэтгэсэн.</p> <p>4) Сонгинохайрхан, ХУД-ын нийт 400 орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг унаа, хүн хүч, бусад техникийн зохион байгуулалтын асуудлыг хариуцан, зонхилон тохиолдох халдварт бус 4 төрлийн өвчний эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулсан.</p> <p>5) БЗДХ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэх дэлхийн аяны үйл ажиллагааг үндэсний хэмжээнд сурталчилж сайн дурын зөвлөгөө шинжилгээнд хамрагдахыг нөхөн үржихүйн идэвхитэй насны нийт 58000 хүнд сошиал медиа ашиглан хүргэсэн.</p>
11	<p><b>Тус байгууллага нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд ямар давуу талууд үзүүлэн орон нутгийн оролцогч талуудад хэрхэн чадварлаг зөвлөгч/түншлэгч байж чадах талаар тайлбарлана уу. (жишээлбэл: арга хэрэгсэл, механизм ашигласан туршлага, зорилтот бүлэгт гарсан үр нөлөө, 5 хүртэлх өгүүлбэрт бичих)</b></p>	<p>Иргэний нийгмийн хүчирхэг манлайлагч нарыг бэлтгэх, олон нийтэд түшиглэсэн байгууллагыг үүсгэн байгуулах санаачлагуудыг манай сүлжээнээс гарган хэрэгжүүлж, сүлжээний санаачлагаар үүсгэн байгуулагдсан олон нийтэд түшиглэсэн байгууллагууд бие даасан ТББ-ууд болтлоо хөгжихын зэрэгцээ Глобаль сангийн салбар хүлээн авагч, хэрэгжүүлэгчээр ажилладаг. Манай сүлжээ нийслэлд төдийгүй орон нутагт үйл ажиллагаа явуулах таатай хөрс суурийг бий болгож чадсан. Мөн манай сүлжээний гишүүн байгууллагууд өөр өөрийн зорилтот бүлэгт өөр өөрийн чиглэлээр үйл ажиллагаагаа олон нийтэд хүргэж ирсэн хангалттай туршлагатай, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах чадавхи бүрэлдсэн. Санхүүгийн чадавхи нөөцөө бэхжүүлснээр цаашид ИНБ-уудын институцыг бэхжүүлэхэд манай сүлжээ манлайлж ажиллах техникийн бүрэн боломж, чадавхи, хүний нөөцтэй болно.</p>
12	<p><b>Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр сонирхож/төлөвлөж буй аймаг/дүүрэг /хэрэв байгаа бол/</b></p>	<p>Баруун 5 аймаг, Өмнөговь, Дорнод, Дорноговь, Хөвсгөл, Орхон, Дархан, Сэлэнгэ</p>
13	<p><b>Тус байгууллагын талаарх дээр дурьдагдаагүй нэмэлт мэдээлэл /3 хүртэлх өгүүлбэр/</b></p>	<p>-Эмэгтэйчүүдийн Нөхөн Үржихүйн Эрүүл Мэндийн Асуудлаарх Азийн бүсийн сүлжээний гишүүн, -Хөгжиж буй орнуудад хөгжлийн төслийн асуудлуудад хүний эрхийн асуудлыг хэрхэн уялдуулах, сайн засаглалыг хөхүүлэн</p>

		<p>дэмжих, иргэдийн оролцоог бий болгох чиглэлээр сонирхон зарим төслүүдэд уригдан оролцож байна.</p> <p>-Дэд бүтцийн хөгжил дэх эрүүл мэнд, хүний эрх, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүрээлэн буй орчны асуудлаар судлан ажиллах хэрэгцээ өндөр байгаа тул энэ чиглэлээр мэрэгшиж эхэлж байна.</p>
14	<p><b>МУНЭХБ төслийн хүрээнд тус байгууллагын мэдээллийг бусад оролцогч талуудад илгээн, цаашид холбоо барихыг зөвшөөрч буй эсэх талаар мэдэгдэнэ үү.</b></p>	<p>Зөвшөөрч байна.</p>